

“ДОРНОД МОНГОЛ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГАА (2010)

Д.ТҮМЭН¹, М.ЭРДЭНЭ², Д.ХАТАНБААТАР³,
Г.АНХСАНАА⁴, Ч.ВАНЧИГДАШ⁵

¹МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим, e-mail: tumen@num.edu.mn

²МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим, e-mail: merdene@num.edu.mn

³ШУТИС, НТС, Түүх-Аялал жуулчлалын профессорын баг, e-mail: hb_parl@yahoo.com

⁴Монгол Цэргийн Музей, e-mail: g.anhaa@yahoo.com

⁵ШУТИС, НТС, Түүх-Аялал жуулчлалын профессорын баг, e-mail:

vanchigdash@must.edu.mn

Түлхүүр үгс: Дорнод Монгол, Дэлгэрхаан уул, Улаан зуух, Хүрлийн үе, Цагаан чулуут, Монгол булш.

ТОВЧ АГУУЛГА: МУИС-ийн Археологи-антропологийн тэнхимийн хээрийн шинжилгээний анги “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2010 онд Дорнод аймгийн Гурван Загал сумын Цагаан Чулуут, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Улаан зуухын оршуулгын газарт ажилласан хайгуул, малтлага судалгааны хэрэглэгдэхүүн, зарим үр дүнгээс гарган тавилаа.

Монголын Дорнод хэсгийг 1920-иод оны үеэс Оросын судлаачид зам зуурын гүймэг судалж, харин 1940-оод оны сүүлчээс Сибирийн судлаач Киселевийн удирдсан Монгол-Зөвлөлтийн хамтарсан экспедиц, Монголын археологоор олон тооны эрдэм шинжилгээний бүтээл туурвисан А.П.Окладниковын удирдсан чулуун зэвсэг судлалын анги ажиллан Дорнод аймгийн Тамсагбулагийн неолитын сууринг илрүүлэн судалсан нь Монголын археологит ихээхэн ач холбогдолтой болжээ. Мөн энэ үеэс эхлэн Х.Пэрлээ, Д.Наваан, Н.Сэр-Оджав, Д.Дорж нар Дорнод Монголд хүрлийн үеийн дөрвөлжин булш ба неолитийн үеийн судалгааг зонхилон явуулсны дүнд хэд хэдэн нэгэн сэдэвт бүтээл хэвлэгдсэн байна. 1940-1970-аад онуудад явуулсан судалгаанаас Дорнод Монголын эртний оршин суугчид нь Төв Азийн түүх, соёл болон угсаатны үйл явцад идэвхтэй оролцогчид байсан нь харагддаг. Гэвч 1970-аад оноос хойш 1990-ээд он хүртэл тухайн нутагт археологийн судалгаа бараг хийгдээгүй бөгөөд 1990-ээд оноос Солонгос, Япон зэрэг улстай хамтран “Гурван гол”, “Дорнод Монгол” зэрэг төслийг тодорхой хугацаанд явцуу сэдвийн хүрээнд зохион явуулжээ.

МУИС-ийн Археологи-антропологийн тэнхмээс Азийн Судалгааны төв (ARC), KFAS (Солонгосын ахисан түвшний судалгааны сан)-ийн санхүүжилтээр 2002-2010 онд Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн нутагт явуулсан археологийн

хайгуул, судалгаагаар Монголын түүхийн янз бүрийн үед холбогдох хэдэн арван дурсгалын цогцолборыг шинээр илрүүлэн, газар зүйн байршлыг тодорхойлон бүртгэж авсан ба зарим цогцолбор дурсгалаас цөөн тооны булшийг малтан судлахад Дорнод Монголын бүс нутаг монголын түүх, монголчуудын гарал үүслийг судлах асуудалд онцгой ач холбогдолтой байж болохыг харуулсан юм. Энэхүү өгүүлэлд “Дорнод Монгол: Археологи-Антроплогийн судалгаа” төслийн хүрээнд 2010 онд Дорнод Монголын нутагт зохион явуулсан археологийн хээрийн судалгааны зарим үр дүнгээс танилцуулж байна.

Нэг. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Улаан зуух орчимд явуулсан археологийн хайгуул, малтлага судалгаа

МУИС-ийн Археологийн судалгааны баг Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан (IV) багийн нутаг Улаан зуух болон Өвдөг, Дунд болон Адгийн гол, Халх хошуу, Донгойн ширээ зэрэг газарт 2010 оны 7 сарын 31-ий өдрөөс 8 сарын 8-ныг хүртэлх хугацаанд археологийн хайгуул, малтлага судалгааг хийж гүйцэтгэв.

1.1. ХАЙГУУЛ СУДАЛГАА

Бид Дэлгэрхаан уулын зүүн, зүүн урд, өмнө, баруун урд хэсэг буюу Өвдөг, Дунд, Адгийн гол, Донгойн ширээ болон сумын төвөөс хойш 21 км-т орших Халх хошуу зэрэг газарт хайгуул судалгаа явуулж, түүхэн олон үед холбогдох археологийн дурсгалуудыг бүртгэн эрдэм шинжилгээний анхдагч баримтжуулалтыг (солбицол тогтоох, тодорхойлолт үйлдэх, хэмжилт хийх зэрэг) үйлдэв. Үүнд:

Улаан зуухад: 64 дөрвөлжин хэлбэрийн болон 1 шоргоолжин булш

Өвдөг: 1 Чулуун хэрэм болон 10 дөрвөлжин хэлбэрийн булш

Адгийн гол: 89 дөрвөлжин хэлбэрийн булш

Донгойн ширээ: Түрэгийн үед холбогдох 1 тахилгын байгууламж

Халх хошуу: Хүннү булш 2, дөрвөлжин булш 9, Монголын үеийн булш 5 буюу нийт 181 булш оршуулгын болон тахилгын байгууламж бүртгэн эрдэм шинжилгээний анхны баримтжуулалтыг хийж гүйцэтгэлээ (Байр зүйн зургийг үзнэ үү).

Дэлгэрхаан уулын орчимд хийсэн хайгуул судалгааны дүнд Улаан зуухын оршуулгын байгууламжтай төстэй бүлэг дурсгалууд болон дагуул байгууламж бүхий өвөрмөц бүтэцтэй дурсгалуудыг шинээр илрүүлэн бүртгэж авлаа. Шинээр илрүүлээд буй эдгээр дурсгалууд нь гадаад зохион байгуулалтын хувьд улаан зуухын булштай ижил төстэй байгаа нь тус соёлын цар хүрээг өргөтгөж буйгаас гадна Улаан зуухад тохиолддоггүй өвөрмөц зохион байгуулалтай булш олноор илэрч байгаа нь сонирхол татаж байна.

Донгойн ширээ

N 46° 34' 03.8"

E 111° 49' 32.4" ALT 1050 m

Дэлгэрхаан (Тахилгат уул) уулаас урагш үргэлжлэх талыг Донгой хэмээдэг ба түүний дунд орших бага шиг тэгш толгойг Донгойн ширээ гэж нэрлэдэг аж. Уул толгойн орой хэсэгт сайтар засан өнгөлсөн урт гонзгой чулууд газарт хугарч унасан байдалтай байгааг нутгийн иргэдийн зааж өгснөөр үзэж танилцав. Ойролцоогоор 300х55х40 см хэмжээтэй 3 босоо хөшөө байсан хэдий ч газарт унан хугарч 8 хэсэг болжээ. Уул чулууд нь боржин чулууг өнгөлөн засаж хийсэн Түрэгийн язгууртны дурсгалд зориулан босгодог гэрэлт хөшөө мэт хэлбэртэй хэдий ч газрын хөрсөн дээр ил байгаа хэсэгт тодорхой бичиг, дүрс сийлэгдээгүй байна. Гэхдээ хамгийн хойд захад орших нэгэн урт чулуун дээр үл мэдэгдэм бүдэг зураасыг цувруулан цохисон маш бүдэг ором мэдэгдэнэ. Хөшөө чулуудын ихэнх хэсэг хөрс шороонд дарагдсан байдалтай байсан ба цаг хугацааны давчуу байдлаас шалтгаалж, газрын хөрсөн доорх хэсгийг эргүүлэн харах боломж байсангүй.

Тус чулуудын урд хэсэгт үргэлжилсэн цэцгэн хээ бүхий гурвалжин хэлбэртэй хавтгай чулуу байна. Уг чулуу нь нэлээд эвдэрсэн хэдий ч одоо байгаа хэмжээгээр 134х140 см ажээ. Ийм төрлийн хавтгай чулуу нийт 5 ширхэг байгаа ба чулуудын ихэнх хэсэг шороонд дарагджээ. Эдгээр хөшөө болон хавтгай чулуудыг үндсэн хэлбэр хийцийн хувьд Түрэгийн хаант улсын үед бүтээгдсэн дурсгалуудтай адилтгаж болохоор байна. Тус цогцолборын төв хэсэгт газрыг нэлээд гүн ухаж, шороог тал тал тийш цацалсан ул мөр тод мэдэгдэх бөгөөд уг үйл ажиллагааны дүнд хөшөө болон тахилгын чулуун хавтангууд эвдэрч сүйдсэн бололтой. Нутгийн хүний яриагаар уул дурсгал эртнээс ийм байдалтай байсан гэх ба лавтай ойрын хугацаанд сүйтгэгдээгүй ажээ. Нутгийн иргэд “...Эрт үед их хор хөнөөлтэй нэгэн хүзүүгүй тэмээ энэ нутгаар хэсүүлэн явдаг байсныг номын хүчээр энд дарсан гэх ба чулуудыг хөдөлгөж, хөндвөл буцан босоож ирнэ...” хэмээн домоглон ярилцдаг ажээ.

1.2. МАЛТЛАГА СУДАЛГАА

УЛААН ЗУУХ ДАХЬ ДУРСГАЛЫН МАЛТЛАГА СУДАЛГАА

Улаан зуух нь Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян сумдын нутгийн зааг, Тогоотын голын доод төгсгөлд оршино. Боржин хад бүхий намхан толгодын дундуур өнгөрөх ширгэсэн булгийн сайран судлыг нутгийн иргэд Тогоотын гол хэмээх бөгөөд уул булгийн баруун дэвсгэ дээр Улаан зуухын дөрвөлжин хэлбэрийн булшнуудын гол төвлөрөл байна. 2008 онд энэхүү оршуулгын газрыг анх илрүүлэн олж шинжлэх ухааны эргэлтэнд оруулан бүртгэл баримтжуулалтыг үйлдсэн билээ. Бид 2010 онд Улаан зуухын оршуулгын газарт бүртгэн авсан нийт 64 булшнаас 7 булшийг сонгон авч малтлага судалгаа хийсэн болно. Эдгээр нь урьд бүртгэсэн дугаарлалтын дагуу 1, 2, 3, 3а, 4, 5, 6-р булшнууд


болох юм. 3а булш газрын хөрсөн дээр мэдэгдэхгүй байсан агаад цэвэрлэгээний явцад гадаад зохион байгуулалт нэлээд эвдэрсэн дөрвөлжин хэлбэртэй байгууламж мэдэгдсэнийг ийнхүү шинээр дугаарлан нэмэлт байдлаар оруулсан болно.

Уг оршуулгын газар нь хойноос урагш үргэлжилсэн нийт 3 эгнээ хэсгээс бүрдэх бөгөөд бид энэ удаад баруун эгнээний хойд захад орших хойноос урагш үргэлжилсэн зүүн хойш чиглэлтэй булшнуудыг малтан судлав. Эхний 2 булш нь хамгийн хойд захад өөр хоорондоо 3 м зайтай бусад булшууд нь дээрх 2 дөрвөлжин хэлбэртэй булшнаас урагш 3 м орчим зайд үргэлжлэн гадаад чулуун дараасаараа нийлэн орших аж. Чулуун байгууламжуудыг ойролцоо орших боржин хаднаас цуулан авсан чулуудыг ашиглан хийсэн байна. Бид 3, 3а, 4, 5, 6-р булшийг нийт (22х6м) талбайгаар нь цэвэрлэн гадаад чулуун хашлагын доод ирмэг хүртэл малтан гаргаж бүтэц, зохион байгуулалтыг тогтоов (Фото зураг 1).

Улаан зуух Булш №1.

N 46° 39' 05.7"

E 111° 51' 41.0" ALT 1073 m



Гар зураг 1. Улаан зуух 1-р булш. Гадаад, дотоод зохион байгуулалт

Оршуулгын газрын хамгийн баруун хойд талд орших жижиг булш. Газрын хөрсөн дээр өнгөц харахад дугуй чулуун дараастай мэт харагдана. Сайн ажиглавал дараасны төв хэсэгт хавтгай чулуудаар өрсөн дөрвөлжин өрлөг ялгарч мэдэгдэх ажээ. Баруун урд буландаа бусдаас өндөр босоо чулуутай. Нийт диаметр 6м. Дөрвөлжин чулуун өрлөгийн хэмжээ 3.35х2.4 м (Фото зураг 2, гар зураг 1). Талбайн төв хэсэгт зүүн хойш чиглэсэн чигжээс чулуугүй хэсэг байгаа нь тонуулчдын үлдээсэн ул мөр байж болзошгүй. Цэвэрлэгээний явцад чулуун дараасны хойд хэсгээс адууны шүд, баруун урд хэсгээс улаан өнгийн ваарны


гурван ширхэг хагархай илрэв. Чулуун дараасны төв хэсэгт 40 см малтахад зүүн хойш чиглэсэн, гол хэсэгтээ цөөн чулуу бүхий бор өнгийн толбо тодров. Толбыг дагуулан малтахад хашлагаас доош 110 см гүнд тоногдсон оршуулга илрэв.

Нас барагчийн хөл, бүсэлхий орчмын яс бүтэн үлдсэн бөгөөд цээжин болон толгой хэсэг анхны байрлалаа алдсан байна. Хүний хөлийн ясны байрлалаас үзвэл нас барагчийг түрүүлгэ нь харуулан тэнэгэр байдалтай оршуулсан ажээ (Фото зураг 3, гар зураг 1). Толгойн орчмоос цагаан өнгийн жижиг чулуун зүүлтүүд олон тоогоор (50 орчим) илэрснээс гадна цагаан өнгийн чулуугаар хийсэн явуу илэрлээ. Нүхний хэмжээ 180х47 см болов.

Улаан зуух Булш №2

N 46° 39' 05.4"

E 111° 51' 41.2" ALT 1074 m



Гар зураг 2. Улаан зуух 2-р булш. Гадаад, дотоод зохион байгуулалт

Улаан зуух №1 булшнаас урагш 3 м зайд орших, зүүн хойш чиглэсэн дөрвөлжин байгууламжтай том булш. Нийт чулуун дараасын диаметр 7х7.5 м, дотоод дөрвөлжин өрлөгийн хэмжээ 3.65х4.20 см (Фото зураг 4, гар зураг 2). Өрлөгийн дотор талд битүү чулуу чигжин хийсэн хэдий ч зүүн урд хэсгийн чулууд анхны байрлалаа алдаж нэлээд эвдэрсэн шинжтэй. Цэвэрлэгээг 25 см гүн хийв. Дөрвөлжин хашлагын дотор хэсэгт малтлагыг үргэлжлүүлэхэд талбайн төв хэсэгт хавтгай чулуун чигжээс бүхий толбо мэдэгдэж байлаа. Гүн 51 см болоход бүх талбайгаар цагаан хөрс буюу байгалын хөрс илэрч талбайн төв хэсэгт 3 ш том хавтгай чулуу тодров. Уг чулуудын дундаас хүний гараар зассан бог малын бололтой шилбэний ясны хугархай илрэв. Эдгээр чулууд нь толбыг таглан тавьсан чигжээс чулууд бөгөөд гол хэсэгт байрлаж байсан нэг чулуу алга болсон бололтой. Уг чулуудын доороос 90 см гүнд оршуулга илрэв. Нүхний хэмжээ

145x50 см. Хүний дунд чөмөгнөөс доош хэсгийн яс анатомийн байрлалаа хадгалан үлдсэн бөгөөд бусад яс анхны байрлалаа бүрэн алдсан байв (Фото зураг 5, гар зураг 2). Анатомийн байрлалаа хадгалан үлдсэн хөлний ясны байрлалаас үзвэл болговол нас барагчийг түрүүлгэ нь харуулан тэнэгэр байдалтай оршуулсан ажээ. Дагалдуулсан эд өлгийн зүйлгүй. 13-16 насны эмэгтэй хүүхдийн оршуулга байна.


Улаан зуух Булш № 3.

N 46° 39' 05.2"


E 111° 51' 41.4" ALT 1070 m

Улаан зуух № 1, 2 булшнаас өмнө тийш 3.3 м зайд орших цувраа 5 булшны хамгийн хойд захад орших булш. Газрын хөрсөн дээр ханалан босгосон цөөн тооны өндөр чулууд, хавтгай дараас чулууд бүхий дөрвөлжин хэлбэрийн байгууламж мэдэгдэж байлаа. I үе. Цэвэрлэгээг 15 см гүн хийхэд зүүн хойш азимутын 70° чиглэсэн дөрвөлжин чулуун байгууламж тодорхой харагдав (Фото зураг 6, 7, Гар зураг 3). Зүүн болон зүүн урд талын чулууд анхны байрлалаа алдаж, эвдэрсэн шинж бүхий байв. Уул байгууламжийг үйлдэхдээ газрын хөрсөн дээр хавтгай чулуудыг 3-4 үе давхарлан тэгш өнцгөөр өрөөд гадуур нь том хавтгай чулуудыг босгон налуулах буюу давхар хашлага болгон, түүнийгээ жижиг чулуудаар даруулжээ. Дөрвөлжин чулуун байгууламжийнхаа гол хэсгийг чулуугаар битүү чигжин хийдэг байсан байна. Чулуун дараасын төв болон баруун урд хэсэгт чигжээс чулуугүй байгаа нь тонуулчдын үйлдсэн ул мөр бололтой. Булшны баруун урд өнцөгт нэгэн том хавтгай чулууг босгон зоосон нь бусдаас өндөр харагдана. Чулуун дараасын хэмжээ 4.1x4 м. Цэвэрлэгээний явцад хойд талын чулуун хашлагын хормой хэсгээс 1 ш адууны шүд, чулуун хашлагын төв хэсгээс хар өнгийн нимгэн ваарны хагархай илэрлээ. II үе - 30 см. Дөрвөлжин чулуун хашлагын төв хэсэгт малтлагыг үргэлжлүүлэхэд талбайн төв хэсгээс маш муу хадгалагдсан хүний ясны үлдэгдлүүд илэрч байв.

III үе - 60 см. Чулуун хашлагын зүүн урд хэсгээс адууны доод үүдэн шүд илэрсэн бөгөөд талбайн төв хэсэгт зүүн хойш чиглэсэн зууван хэлбэрийн эмх замбараагүй чулуун чигжээс бүхий толбо илрэв. Хэмжээ 180x62 см. Толбыг дагуулан малтахад хүний нугалам нуруу, хавирганы яснууд гарсаар байлаа. Толбо илэрснээс доош 46 см гүнд оршуулга илрэв. Хүний гавал, зүүн талын хавирга болон нугалам нуруунаас бусад яс анатомийн байрлалаа хадгалан үлдсэн байна. Нас барагчийг түрүүлгэ нь харуулан, зүүн хойш хандуулж, гарыг нь их биеийн дагуу сунган тэнэгэр байдалтай оршуулжээ (Фото зураг 8. Гар зураг 3). Зүүн хөлийн тавхайг хойш чиглүүлэн нугалсан байна. Залуухан эрэгтэй хүний оршуулга. Дагалдуулсан эд өлгийн зүйл үгүй. Хүний ясны хадгалалт муу. Малтлагын нийт гүн 106 см.



Гар зураг 3а. Улаан зуух 3-6 булшны гадаад зохион байгуулалт



Гар зураг 3б. Улаан зуух 3-6 булшны дотоод зохион байгуулалт, оршуулга

Улаан зуух Булш № 3а.

N 46° 39' 05.2"

E 111° 51' 41.4" ALT 1070 m

Улаан зуух № 3 болон № 4 булшийг холбосон цөөн тооны чулууд газрын хөрсөн дээр мэдэгдэж байлаа. Бүх талбайгаар малтах явцад 40 см гүнд баруун болон зүүн талын хашлага нь эвдэрч тодорхойгүй болсон, зүүн хойш чиглэсэн дөрвөлжин хэлбэрийн чулуун байгууламж илэрснийг Улаан зуух № 3а хэмээн тэмдэглэлээ. Толгой талын өрлөг мэдэгдэхгүй шахам хөл талд нэг хавтгай босоо чулуу байгаа нь өрлөгийн гадна хашлага бололтой. Гадна хашлагыг бүрэн гаргаж 60 см гүн малтахад хашлагын зүүн хойд хэсгээс хүний ясны хугархай илрэв. Хашлагын хэмжээ 3.9х2.6 м.

Малтлагын III үе. Хашлагын төв хэсэгт 50 см малтахад хашлагын толгой, хөл талын өрлөг тодорхой мэдэгдэж эхлэв. Малтлагын энэ түвшинд талбайн төв хэсэгт өргөргийн дагуу чиглэлтэй зууван хэлбэрийн чигжээс чулуу илэрсэн бөгөөд тэдгээрийн доороос булшны толбо бүдэг мэдэгдэж байна. Толбоны толгой хэсэгт нэгэн хавтгай чулууг дамналдуулан тавьсан нь нүхний хамгаалалт чулуу бололтой. Уг чулууны хэмжээ 106х63 см.

Толбоны дунд хэсгээс малын яс илэрч байв. Гүн 70 см болоход хашлагын дагуу чиглэлтэй 65х210 см толбо илэрч түүний төв хэсгээс хүний хавирга, нурууны нугалам, хурууны үений яснууд бөөгнөрсөн байдалтай, мөн цагаан өнгийн жижиг ясан, чулуун зүүлтүүд илэрлээ. 85 см гүнд оршуулга илрэв. Хүний толгой, цээжин хэсэг тонуулчийн гарт өртөн анатомийн байрлалаа алдсан байна. Гавлын яс үгүй. Хөл, гар, бүсэлхий орчмын яс анхны байрлалаа хадгалан үлдсэн байснаас үзвэл нас барагчийг зүүн урд зүгт тэргүүнийг нь хандуулан, 2 гарыг их биеийг дагуулан сунгаж, тэнэгэр байдалтай түрүүлгэ нь харуулан оршуулсан байна (*Фото зураг 9, 10. Гар зураг 3*). Хүний баруун бугалганы гадна талд болон толгойн орчмоос цагаан өнгийн чулуун зүүлт олон тоогоор (100 гаруй ш) олдов. Толгой хэсгээс хүний 6 ш шүд илрэв.

Улаан зуух Булш № 4

N 46° 39' 05.0"

E 111° 51' 41.7" ALT 1071 m

3.6х3.3 м хэмжээтэй тэгш бус дөрвөлжин хэлбэртэй цөөн тооны чулуун дараастай 3а-р булштай залган орших бага шиг булш. Толгой орчмын өрлөг нэлээд эвдэрсэн шинжтэй. Төв хэсэгтээ бараг чулуугүй. Толгой орчимд байх хашлага чулууны өндөр 50 см. Уг булшны баруун хойд хашлаганы гадна талаас 1ш бог малын хавирганы яс илрэв. Малтлагыг талбайн төвд үргэлжлүүлж 40 см гүн малтахад зүүн хойш (80°) чиглэсэн жижиг чулуун хашлага илрэв. Хэмжээ 190х60см. Хашлагын хөл хэсгийг 2 урт хавтгай чулуугаар хашин хийжээ. Чулуун хашлага бүхий оршуулга байсан хэдий ч маш их тоногдсон байна. Уг хашлагын дотор талд 60 см гүн малтахад маш муу хадгалагдан үлдсэн хүний дунд чөмөг,

шаант, бугалга, хавирга зэрэг яснууд маш эмх замбараагүй байдалтай илэрлээ. (Фото зураг 9, 11, Гар зураг 3).

Улаан зуух Булш № 5

N 46° 39' 04.9"

E 111° 51' 41.9" ALT 1070 m

4.6х3.4 м хэмжээтэй. Дөрвөлжин чулуун өрлөг бүхий булш. Зүүн талдаа бусдаас өндөр (50 см) хөшөө чулуутай. Цэвэрлэгээг гадна хашлагын суурь хүртэл гүн (60 см) хийж, талбайн төв хэсэгт үндсэн малтлагыг үйлдэв. 60 см гүнд 151 см урт, 51 см өргөн зүүн хойш (60°) чиглэсэн толбо илрэв. 72 см гүнд оршуулга илрэв. Маш их тоногдож эмх замбараагүй байдалтай болсон хүний дунд чөмөг, шилбэ, сүүж, дал болон хавирганы яснууд илэрлээ. Археологийн эд өлөг илэрсэнгүй. Насанд хүрсэн эрэгтэй хүний оршуулга байжээ (Фото зураг 12, 13, 14, 15, 16, Гар зураг 3).

Улаан зуух Булш № 6

N 46° 39' 04.8"

E 111° 51' 42.0" ALT 1070 m

Хамгийн урд захад орших том булш. Бид уг булшны гадаад зохион байгуулалтыг бүрэн тодруулах үүднээс гадна дотор хашлагыг бүрэн гаргаж, цэвэрлэв. Хэмжээ 4.2х5.7м. Дөрвөлжин хэлбэртэй чулуун байгууламж бөгөөд гадаад зохион байгуулалт эвдэгдээгүй шинжтэй. Баруун урд буландаа бусдаас өндөр чулууг зоосон. Уг чулууны өндөр 48 см. Дараасын төв хэсэгт хавтгай том чулуудыг битүү чигжин хийсэн. Нас барагчийн толгой мөрний хэсэг тонолтонд өртсөн, анхны байрлалаа хадгалан үлдсэн бусад яснуудаас харахад эмэгтэй хүнийг түрүүлгэ нь харуулан тэнэгэр байдалтай оршуулсан байна. Хар өнгийн шавар ваарны хагархай, засаж хийсэн чулуун нухуурны хугархай зэрэг археологийн эд өлгийн зүйл илрүүлэн олов. Нүхний гүн 75 см. Хэмжээ 2.10х90 см болжээ. (Фото зураг 17, 18, 19, Гар зураг 3).

УЛААН ЗУУХ ДАХЬ ДУРСГАЛЫН ТУХАЙД

Байгаль газар зүйн орчин. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Хантай багийн нутаг Дэлгэрхаан уулын зүүн суга болох Гүн ус хэмээх газар нь хойноос урагш үргэлжилсэн жижиг ам буюу боржин хадтай бэсрэг толгодоос бүрдэнэ. Энэхүү амны доод төгсгөл орчмыг Улаан зуух гэх ба тэнд орших 63 булшийг анх 2008 онд бүртгэж, дийлэнх нь “Дөрвөлжин хэлбэртэй” булш болох талаар дурьджээ (Наваан ба бусад, 2008: 26). Урьд хэвлүүлсэн өгүүлүүдэд эдгээр дурсгалуудыг дөрвөлжин булш хэмээн нэрлэж байсныг энэ удаад татгалзаж дөрвөлжин хэлбэртэй булшнууд хэмээн тодотгон нэрлэхээр шийдлээ. Эдгээр дурсгалууд нь хүрэл зэвсгийн үеийн голомт соёлын нэг болох дөрвөлжин

Хүснэгт 1.

УЛААН ЗУУХЫН ОРШУУЛГЫН ГАЗАРТ ХИЙГДСЭН МАЛТЛАГА СУДАЛГААГААР ИЛЭРСЭН ОЛДВОРУУДЫН ФОТО
ЗУРГИЙН КАТАЛОГИ

Д/д	Олдворын нэр	Булш, Лабораторийн дугаар	Товч тодорхойлолт	Фото зураг
1	Ясан эдлэл	Б- 2 УЗ-2-1	<i>Бог малын ясаар хийсэн эдлэл. Урт 12 см. Нэг үзүүрийн хэсэг нь хугарсан байдалтай. Нөгөө үзүүрийн ирмэгийг 2 нарийн зураасаар эмжсэн байна. Хадгалалт сайн.</i>	
2	Вааран савны хагархай	Б- 1 УЗ-1-1	<i>Улаан хүрэн өнгийн ваарны хагархайнууд. 6 ш. Шатаалт муутай. Бүдүүн ширхэгтэй. байна. Элдэв хээ чимэглэл үгүй.</i>	

3	Чулуун явуу	Б- 1 УЗ-1-2	<i>Цагаан өнгийн зөөлөн чулуугаар явуу мэт хэлбэр гарган засаж хийсэн зүйл. Хүзүүний зүүлтний хэсэг байсан бололтой, нэг үзүүрт нь нүх гарган цоолсон хэдий ч тэр нь сэтэрсэн ажээ.</i>	
4	Чулуун сувс	Б- 1 УЗ-1-3	<i>Яс болон цагаан өнгийн чулуудаар хийсэн сувснууд. Нийт 53 ширхэг.</i>	
5	Чулуун сувс	Б- 3а УЗ-3а-1	<i>Яс болон цагаан өнгийн чулуудаар хийсэн сувснууд. Нийт 112 ширхэг.</i>	

булшнаас гадаад, дотоод зохион байгуулалт, оршуулгын зан үйлээр ялгаатай байгаа тул дөрвөлжин хэлбэрийн булш хэмээн ялган нэрлэж байгаа билээ.

Тархац. Ийм төрлийн дурсгалууд нь тус нутгийн тахилгат хайрхан болох Дэлгэрхаан уулыг тойрон Булгийн эх, Билүүтийн гол, Булгийн адаг, Тогоотын гол зэрэг газраар тархсан болохыг хайгуул судалгаагаар тогтоогоод байгаа ба энэ орчмын бусад газруудад ч ийм төрлийн дурсгал байх боломжтой. Гадаад зохион байгуулалтын хувьд үүнтэй адил дурсгал гадаад дотоодын мэргэжлийн хэвлэлд нийтлэгдээгүй байгаагаас үзвэл зөвхөн энэ бүсэд тархсан дурсгал бололтой. Бид Дэлгэрхаан уулын баруун, зүүн, өвөр бэлээр хайгуул судалгаа явуулсны дүнд Улаан зуухын булшнуудтай ижил гадаад зохион байгуулалт бүхий 180 гаруй дурсгал бүртгэж, баримтжуулсан болно. Дээрх шинээр илрүүлсэн дурсгалууд нь гадаад зохион байгуулалтын хувьд дөрвөлжин хэлбэр бүхий чулуун өрлөг (30-50 см) түүнийг түшүүлэн босгосон хавтгай чулуун хашлагатай байна. Мөн уг булшнууд нь нэг доор ойролцоогоор 6-15-аар бүлэглэн орших агаад ихэнх тохиолдолд дээрх бүлэг булшнуудын зүүн талд намхавтар хөшөө чулуу эсвэл зүүн тийш цувруулан босгосон хөшөө чулууд тохиолдох ажээ. Цөөн тохиолдолд баруун талдаа цувраа чулуудтай байдаг. Зарим бүлэг булштай залгаа Улаан зуухын оршуулгын газар тохиолддог барилгын суурь мэт том чулуун байгууламжууд тааралддаг. Чулууг ирмэгээр нь газар шигтгэж хийсэн байшингийн өрөө тасалгааг санагдуулам зохион байгуулалт бүхий дөрвөлжин хэлбэрийн байгууламжуудаас гадна цагариг хэлбэртэй ч тохиолддог.

Гадаад зохион байгуулалт. Улаан зуухад малтан судалсан булшнууд тэгш дөрвөлжин хэлбэртэй, баруун урдаас зүүн хойд зүг чиглэсэн байрлалтай байдаг. Төв дундаа хавтгай чулуугаар дөрвөлжин хэлбэр гарган өрлөг (цаашид дотор өрлөг хэмээнэ), түүний гадна талаар том хавтгай чулуудыг босгон давхар хашлага (гадаад хашлага) үйлджээ. Гол төлөв зүүн болон хойд талын хашлагыг бусдаас өндөр хийдэг. Ойр орчмын боржин хаднаас цуулан авчирсан хавтгай чулуудаар хашлагыг үйлдэж, хашлагын дотор талд жижиг чулуудыг битүү чигжин хийжээ. Зарим нь зөвхөн зүүн хойд буландаа хөшөө чулуутай байна. Уг зохион байгуулалтын хэлбэр дөрвөлжин булшийг дагнан судалж, гадаад зохион байгуулалтын ангилал үйлдсэн судлаачдын бүтээлд алга байна. Тиймээс ийм төрлийн булш Монгол нутагт анх тэмдэглэгдэж байна гэж үзэж болох юм.

Оршуулгын зан үйл. Энд малтсан булшинд хүнээ гүн бус нүхэнд толгойг нь зүүн хойд зүгт хандуулан, түрүүлгэ нь харуулан тэнэгэр байдалтай оршуулдаг ба хүүхэд болон насанд хүрсэн хүний оршуулгын хооронд тодорхой зан үйлийн ялгаа харагддаггүй. Дагалдуулсан эд зүйлсэд Улаан зуухын 42-р булшнаас чулуун эдлэл (Наваан ба бусад, 2008: 13), 1, 3-р булшнаас цагаан өнгийн чулуу болон ясан сувс (200 орчим), чулуугаар хийсэн хясаа хэлбэрт эдлэл, ясан эдлэл, шавар ваарны хагархай зэрэг орно. Улаан зуухын 42-р булшнаас илэрсэн чулуун эдлэлтэй төстэй эдлэл ОХУ-ийн Буриадад малтсан Оловенная 2-р дөрвөлжин булш, Кунга-ын 1-р булшнаас тус тус илэрсэн бөгөөд, А.Д.Цыбиктаров тэдгээр

олдворыг Ацайн (МЭӨ VIII-VI) шатанд холбогдуулан ямар нэгэн зүйлийг ирлэхэд зориулсан билүү гэжээ. Тэдгээр булшууд нь гадаад зохион байгуулалтын хувьд өндөр чулуун хашлагатай дөрвөн буландаа хөшөө чулуутай байжээ (Цыбиктаров, 1998: 283). Мөн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг Майхант уулын шинэ чулуун зэвсгийн бууцны орчимд хийсэн хайгуулын явцад үүнтэй адил дээрээ нүхтэй, зассан чулуун эдлэл түүвэр байдлаар олдсон билээ (Наваан ба бусад, 2009). Мөн Увс аймгийн Улаангомын 9-р булшнаас ийм төрлийн чулуун эдлэл гарсныг чулуун билүү хэмээн үзсэн байдаг (Новгородова, 1989: 273).

Мөн эндээс илэрсэн хар, улаан өнгийн шавар ваар савны үлдэгдэл, чулуун сувс зэрэг нь дөрвөлжин булшны оршуулгын зан үйлд түгээмэл хэрэглэгддэг эд өлгийн зүйлс юм. Одоогоор уг оршуулгын газраас илрээд буй археологийн олдворууд нь дөрвөлжин булшнаас түгээмэл илэрдэг эд өлгийн зүйлстэй нийцэж байгаа нь энэхүү соёлтой тодорхой хэмжээгээр холбогдохыг харуулж байна.

Тус оршуулгын газарт малтан судалсан 42, 5, 6-р булшнаас илэрсэн хүний ясанд хийсэн C^{14} -ийн шинжилгээгээр 42-р булш нь МЭӨ 1310-1210 он, 5-р (А) булш МЭӨ 1431-1326 он, 6-р (В) булш МЭӨ 1408-1361 оны үеийнх болохыг тогтоолоо (C^{14} -ийн шинжилгээг Японы “Polyno Survey 3” компаний он цаг тогтоох лабораторит судлаач Hashimoto Markio, Kanai Shinji нар хийсэн болно). Энэ нь Улаан зуухын дурсгалт газар МЭӨ XV-XIII зуунд холбогдох боломжийг харуулахаас гадна 200 илүү жилийн турш нас барагчаа хөдөөлүүлж байсан оршуулгын газар болохыг илтгэж байна.

Улаан зуухын булшнуудын оршуулгын зан үйлийн гол онцлог бол нас барагчаа түрүүлгэ нь харуулан оршуулах явдал юм. Энэ нь түүнийг тус үеийн бусад археологийн соёлуудаас ялгах гол шинж болгож байна. Түрүүлгэ нь харуулан оршуулах зан үйл Төв Азийн эртний нүүдэлчдийн дунд тун ховор тархсан байдаг ажээ. Одоогоор нас барагчаа түрүүлгэ нь харуулан оршоосон оршуулга Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулнаа малтсан 5 хэлбэрт булшнаас (Новгородова, 1989), мөн уулын баруун урд орших Хад үзүүрт малтсан шоргоолжин болон “Дөрөө” хэлбэрийн булшнаас, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Баруун Гялаатад малтсан 1 шоргоолжин булш болон Замын бууцын 1-р булшнаас (Эрдэнэбаатар, Ковалев, 2009), Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Умдаан голын хэлбэрт булшнаас (Цэвээндорж ба бусад, 2005a; дам ишлэл), Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойд малтсан 16-р (шоргоолжин) булшнаас (Түмэн ба бусад, 2008), мөн аймгийн Гурвантэс сумын Хөөрхөн толгойн 4-р булш (Түмэн ба бусад, 2010: 51), Хадат толгойн 1, 3, 6-р булш буюу төв дундаа дөрвөлжин хэлбэрийн чулуун дараастай булш болон 6-р шоргоолжин булшнаас (Түмэн ба бусад, 2010: 14, 17, 21), Өмнөговь аймгийн Ухаа худагийн дугуй чулуун дараастай булш (Амартүвшин ба бусад, 2008), Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт малтсан 3 шоргоолжин булш (Амартүвшин ба бусад, 2008), Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань хар уулнаа малтсан дөрвөлжин чулуун хашлагатай 8 булшинд (Амартүвшин ба бусад, 2007: 141),

Говь-Алтай аймгийн Улаанбоомын хавцалд (Цэвээндорж ба бусад, 2005б), Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны Бага Монголын 1-р хэлбэрт булш, Дунд шандын 1-р булш (Амартүвшин, Жаргалан, 2008) -аас тус тус илрээд байгааг судлаачид нийтэлжээ.

Нэгтгэн үзвэл түрүүлгэ нь харуулан оршуулсан оршуулга нь Монголын төв болон өмнөд бүсээс олдсон ба ойролцоогоор 30 орчим тохиолдол тэмдэглэгджээ. Эдгээрээс дийлэнх нь (14 тохиолдол) шоргоолжин (Хэлбэрт) булш болох бөгөөд дээрх судлаачдын тодорхойлсноор дугуй дараас дөрвөлжин хашлагатай 11, дугуй хэлбэрийн 1, дөрөө хэлбэрийн 1, тодорхой хэлбэргүй 4 булш бүртгэгджээ.

Археологич Ч.Амартүвшин нар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Чандмань Хар уулнаа нас барагчаа түрүүлгэ нь харуулан оршуулсан дугуй хэлбэртэй, дөрвөлжин хашлагатай 8 булш малтан судлаад түүнийхээ хэрэглэгдэхүүнийг Монгол, Өвөр Байгальд малтан судалсан хүнээ түрүүлгэ нь харуулан оршуулсан оршуулгуудтай харьцуулан, холбогдох угсаатны зүйн мэдээ баримтуудыг дурьдан ёс бусаар буюу онцгой тохиолдлоор нас барсан хүнийг оршуулах хэлбэр байжээ хэмээн үзсэн байна (Амартүвшин ба бусад, 2007: 141). Судлаачид тэдгээр булшийг хүрлийн эхэн үе, магадгүй Энеолитийн үед холбогдох бололтой хэмээжээ. Мөн тэд БНХАУ-ын Цзянсу мужийн Юйдуны неолитийн соёл Ючиний Цинльньчаны 25 булшны 23-т нь ийм зан үйл ажиглагдсан тухай дурьдсан байна.

Судлаач Д.Эрдэнэбаатар “Тэвшийн соёл” хэмээх нэр томъёог гарган тавьж, дотор нь шоргоолжин болон “дөрөө” хэлбэрийн оршуулгын байгууламжийг багтаагаад ... “дөрөө” хэлбэрийн булш гэж нэрлэж байгаа булшны оршуулгын зан үйл, “шоргоолжин” хэлбэрийн булшинд хүнээ түрүүлгэ нь харуулж тавьсан байгаатай ижил зан үйлтэй учраас уг дурсгал “Тэвшийн соёл”-д хамаарна гэдгийн давхар баталгаа болно... хэмээн үзээд түрүүлгэ нь харуулан оршуулах зан үйл нь “дөрөө” болон шоргоолжин булшийг нэгэн соёлын хүрээнд багтаан авч үзэх гол үндэслэл гэж үзжээ (Эрдэнэбаатар, Ковалев, 2009).

Гэхдээ бидний дурьдан буй булшууд нь гадаад хэлбэрийн хувьд шоргоолжин (хэлбэрт) булш болон “дөрөө” хэлбэрийн булштай адилгүй хэдий ч дотоод зан үйлийн хувьд хүнээ түрүүлгэ нь харуулан оршуулсан байдгаараа ижилсэж байгаа нь туйлын сонирхолтой. Тус дурсгал нь орших байр зүй, гадаад хашлага, булшны үндсэн чиглэл, нүхний гүн, нас барагчийн тэргүүнийг хандуулах зүг чиг төдийгүй илэрч буй олдворуудаараа дөрвөлжин булшны соёлын зан үйлийн элементүүдийг харуулж байгаа ч гадаад зохион байгуулалт (дотор өрлөг), оршуулгын зан үйл (түрүүлгэ нь харуулан оршуулах) нь шоргоолжин (хэлбэрт) булштай адил байгаагаас уг дурсгалын соёлын хамаадлын асуудлыг тусгайлан авч үзэх шаардлага урган гарч байна.

УЛААН ЗУУХЫН ДУРСГАЛЫН СОЁЛЫН ХАМААДЛЫН АСУУДАЛД

Монголын хүрлийн үеийн дөрвөлжин болон шоргоолжин булшны дурсгалтай харьцуулсан судалгаа

Н.Н.Диков (1958: 108), А.П.Окладников, И.И.Криллов (1980), З.Батсайхан (2002: 140), Д.Эрдэнэбаатар (Эрдэнэбаатар, Ковалев, 2009) нар шоргоолжин булш нь дөрвөлжин булшны соёлыг үлдээгчдээс ялгаатай гэж үздэг. Судлаач З.Батсайхан Пестеровад малтсан шоргоолжин булшны олдворын дээжийн C¹⁴-ийн аргаар шинжлэн МЭӨ 1540 хэмээн тогтоосон үнэмлэхүй он цаг ба Тэвшийн шоргоолжин булшнаас гарсан Аргалын толгойн дүрстэй алтан хавчаар нь Карасукийн буюу хөгжингүй хүрлийн үед (МЭӨ XVI-XIII) холбогдож буй зэргээс “Шоргоолжин булш дөрвөлжин булшнаас түрүү үеийн дурсгал байж болох ба угсаа гарвалаараа өөр овог аймгийн дурсгал бололтой. Тэдгээрийн хооронд ажиглагдах ялгааг тухайн соёлын доторх нийгмийн онцгой бүлэг гэж үзэх нь зарим талаар эргэлзээ төрүүлж байна (2002: 140) гэжээ.

П.Б.Конавалов, В.В.Свинин, М.А.Зайцев нар ерөөсөө шоргоолжин булш оршдог эсэхэд эргэлздэг (Амартүвшин, 2003: 47), А.Д.Цыбыктаров “шоргоолжин булш”-ны соёлыг үлдээгчдийн угсаа соёлын асуудлыг шийдэх хангалттай эх сурвалж одоогоор бий болоогүй (Цыбыктаров, 1998: 126-128) гэж үздэг ажээ. Харин В.В.Волков (1967), Г.И.Боровка (1927: 61-62; Амартүвшин, 2003: 49-өөс дам ишлэл), Г.П.Сосновский (1928 дам ишлэл), С.В.Киселев (1947: 355-372), Ю.С.Гришин (1980: 12-14), Ч.Амартүвшин (2003: 48) нар дөрвөлжин ба шоргоолжин булшны соёлыг нэгэн хүрээнд багтаадаг.

Г.И.Боровка Монгол, Өвөрбайгальд малтсан 18 шоргоолжин булшнаас зуурмаг, мана, оюу сувсууд, хүрэл товч, алтан хавчаар, билүү, шавар савны хэлтэрхий гарсан нь (1927: 61-62, Амартүвшин, 2003: 49, дам ишлэл) эд өлгийн бүтэц төрөл зүйлийн хувьд дөрвөлжин булштай ижилсэж байгаа ба энэ нь энэхүү хоёр соёлыг нэгэн хүрээнд багтаах гол үндэслэл гэжээ.

Ч.Амартүвшин дөрвөлжин ба шоргоолжин булш нь археологийн нэгэн соёлын хүрээнд багтах боловч оршуулгын байгууламжийн өвөрмөц хувилбарууд болох ажээ (2003: 48), мөн хожим цөөнгүй илрэх болсон зан үйлийн өвөрмөц хэлбэр болох түрүүлгэ нь харуулан оршуулсан оршуулгын шинэ хэрэглэгдэхүүн сэлтэд тулгуурлаж, Чандмань хар уулнаа малтсан дугуй дараастай дөрвөлжин хашлагатай булшнууд нь... Хүрэл зэвсгийн түрүү үеийн соёлууд дотроос ялгамжтай дурсгал байсан болов уу? гэжээ (Амартүвшин, Жаргалан, 2008).

Оросын судлаач Ю.С.Гришин тэдгээрийг нэгэн хүрээнд багтааж, дөрвөлжин булшны хүрээнд багтсан тусгай угсаатны бүлэгт холбогдуулсан ба элгээр нь доош харуулан тавьсан булш мөн хэсэгчлэн чандарласан зэрэг оршуулгын зан үйлийн онцлогоороо ялгаатай (1980: 12-15) гэж үзсэн байхад А.Д.Цыбыктаров тэдгээрийн тархалт үндсэндээ адил тул угсаатны ялгаагаар тайлбарлах нь учир дутагдалтай бөгөөд зарим шоргоолжин булшнаас үнэт эд

зүйлс гардаг, хүнээ өвөрмөц байдлаар тавьдаг, гадаад байгууламж нь том хэмжээтэй зэргийг цохон тэмдэглээд цөөн тоотой онцгой байр суурьтай хүмүүст зориулсан булш болов уу? хэмээн үзсэн байна (Амартүвшин, 2003: 48, дам ишлэл).

Энэ мэтээр судлаачид шоргоолжин болон дөрвөлжин булшны хоорондын хамаарлын талаар авч үзсээр ирсэн хэдий ч тэдгээрийг нэгэн хүрээнд багтаах эсвэл үгүйсгэхэд оршуулгын зан үйлийн өвөрмөц хэлбэр болох түрүүлгэ нь харуулан оршуулах хэлбэр гол үндэслэлийн нэг болж чадалгүй өдийг хүрчээ.

Улаан зуухын дөрвөлжин хэлбэрт булшнууд нь шоргоолжин (хэлбэрт), дөрөө хэлбэрийн булштай оршуулгын дотоод зан үйлийн хувьд ижилсэх бөгөөд гадаад зохион байгуулалтын үндсэн шинж, эд өлгийн хувьд дөрвөлжин булшны соёлтой холбогдож, дээрх соёлуудыг нэгэн хүрээнд авч үзэх шижим болох боломжтой чухал дурсгалт газар болохыг судалгааны урьдчилсан үр дүн харуулж байна. Улаан зуух орчмын дурсгалууд нь урьд өмнө судлаачдын хараанд өртөж, эрдэм шинжилгээний эргэлтэнд ороогүй чухал дурсгалууд бөгөөд Монгол, Өвөр байгаль, Өвөр Монгол, Шинжаан, Манжуурын бүс нутагт тархсан хүрэл зэвсгийн дунд үед холбогдох дөрвөлжин булшнуудаас гадаад зохион байгуулалт, оршуулгын зан үйл, дагалдуулж тавьсан эд өлгийн зүйлсээрээ эрс ялгаатай ба цаашдын судалгааны явцад олон ээдрээтэй асуултанд хариулт өгч болох чухал оршуулгын газар ажээ.

Хоёр. Дорнод аймгийн Гурванзагал сумын нутагт явуулсан археологийн хээрийн судалгаа

МУИС-ийн археологийн хээрийн шинжилгээний анги Дорнод аймгийн Гурванзагал сумын нутагт 2010 оны 8 сарын 12-оос 18-ныг хүртэл хугацаанд археологийн хайгуул, малтлага судалгааг хийж гүйцэтгэхдээ Хадан хөвөө, Бор толгод зэрэг газруудад хайгуул судалгаа, Цагаанчулуутад малтлага судалгааг явуулсан болно.

2.1. МАЛТЛАГА СУДАЛГАА

Гурванзагал сумын төвөөс зүүн урагш 12 км орших Цагаан чулуут хэмээх газар Монголын үед холбогдох (X-XIII зуун) 8 булш малтан судлав. Урьд жилүүдэд энэхүү газарт ажиллахдаа тус толгойн ойр орчимд 163 булш илрүүлэн бүртгэж, баримтжуулсан бөгөөд уул бүртгэлийн дугаарын дагуу 6, 7, 10, 12, 18 дугаар булш болон шинээр илрүүлэн олсон 164, 165, 166-р булшуудыг малтан судалсан болно.


Гурванзагал сумын төвөөс зүүн урагш 100° хэмд 12 км зайд Цагаан чулуут хэмээх 3 залгаа толгой бүхий уул оршино. Сумын төвөөс зүүн урагш Цагаан чулуут хүртэлх жижиг горхи бүхий өргөн хөндийг Рашаантын хөндий гэх бөгөөд тус уулын баруунаас Гүн жалгатын хөндий болон үргэлжилдэг байна. Цагаан чулуутын урд тодхон харагдах орой хэсэгтээ цагаан чулуу бүхий 2 жижиг толгойг

Баруун цагаан өргөө, Зүүн цагаан өргөө хэмээн нэрийддэгээс тус уулын нэр үүссэн гэдэг.

Цагаан чулуут 6-р булш

N 49° 05' 25 3"

E 115° 02' 271" ALT 948 m



Гар зураг 4. Цагаан чулуут 6-р булш.
Гадаад зохион байгуулалт

Том хэмжээний хавтгай чулуудаар хойд зүг чиглүүлэн байгуулсан дугариг чулуун өрлөгтэй булш. 6.6x7м хэмжээтэй. Булшны төв хэсэгт том хэмжээний хавтгай чулуудыг голдоо дөрвөлжин хэлбэр үүсэхээр байрлуулж, тус бүрийн амыг жижиг чулуугаар дарах байдлаар чулуун дараасыг байгуулжээ. Дараасын төв хэсэгт хойд зүг чиглэсэн чулуугүй, хонхор байна. Чулуун дараасыг цэвэрлэх явцад талбайн төв хэсгээс бог малын хугархай шаант яс илрэв. Чулуун дараасыг зайлуулан талбайн төв хэсэгт 3.4x3.1 м хэмжээгээр эртний өнгөн хөрснөөс доош 30 см гүн малтахад талбайн хөл хэсэгт 1.5x1.2м хэмжээтэй том чулууг нүхний таглаа байдлаар

байршуулсан байна. Толбыг илрүүлэн олж, дагуулан малтахад 1.1 м гүнд нүхний төв хэсгээс хүний богтос яс болон сэнжийг нь дээш харуулан тавьсан төмөр дөрөө илрэв. 1.2 м гүнээс булшны төв хэсгээс нэг талдаа сэнж бүхий хүрэл гархи 2 ш, жижиг төмөр дөрөө, төмөр болон модон эдлэлийн үлдэгдэл, маш муу хадгалагдсан модон иштэй төмөр хутга зэрэг зүйлс илэрлээ. Мөн энэ гүнд булшны толгой хэсгээс голдоо хавтгай хүрэл эдлэл бүхий эмээлийн төмөр баавар мэт зүйл олдлоо. Эртний өнгөн хөрснөөс доош 146 см гүнд 3 ш төмөр зэв бүхий үйсэн хоромсогыг сум хийх амсрыг хойд зүгт харуулан тавьжээ. Хоромсого муу хадгалагдсан бөгөөд газар дээр хэмжилт хийхэд 80 см урт 18 см өргөнтэй байлаа. Түүний дээд талд бог малын далны яс, жижиг төмөр хутга босгон тавьсан байсан нь тонуулчдад хөндөгдөлгүй үлдсэн байна. Оршуулгын нүхний хэмжээ 241x123 см бөгөөд толгой хэсэгт банзан шалны үлдэгдэл харагдаж байлаа. Нас барагчийг банзан авсанд оршуулсан байсан хэдий ч тонуулчдын үйл ажиллагааны улмаас бүрэн сүйдэж, дагалдуулж тавьсан эд өлгийн зүйлсээс сум бүхий хоромсого, бог

малын дал, төмөр хутга зэрэг зүйлс анхны байрлалаа хадгалан үлдсэн байна (Фото зураг 20, Гар зураг 4).

Олдворын тодорхойлолт:

Зэв:

1-р зэв: Солон морьч хар зэв. Урт 14.4 см, сурвалжны урт 5.6 см

2-р зэв: Хануур сум. Урт 10.8, сурвалжны урт 2.7 см. Мөтгөны өргөн 2.2 см.

3-р зэв: Суман зэв. Урт 12.1 см, сурвалжны урт 4.1 см.

4-р зэв: Хануур сум. Урт 10.5 см, сурвалжны урт 3.3 см.

5-р зэв: 4 талт суман зэв. Урт 7.8 см, сурвалжны урт 2.1 см.

6-р зэв: Хугархай төмөр зэв. Зөвхөн сурвалжийн хэсэг үлдэж хоцорчээ.

Хүрэл сэнж: 2ш. Нэг үзүүртээ цагариг гогцоо бүхий хавтгай хүрэл эдлэл. Сэнж хэсэгтээ ямар нэгэн зүйлд тогтоох зориулалт бүхий нүхтэй. Цагариг диаметр 1.3 см, сэнжний урт 1.6 см.

Төмөр эдлэл: Хадгалалт муутай хавтгай төмөр эдлэл байх ба түүний дунд хэсгээс нимгэн хавтгай хүрэл ялтас цухуйсан байдалтай. Хэлбэр тодорхойгүй. Хэмжээ 6.2х5.3 см, зузаан 2 см.

Төмөр хутга: Нимгэн төмөр хутга, муу хадгалагдсан. Урт 12.1 см, өргөн 1.1 см. Төмөр хутга болох нь бариулд зоогдох углуурганаас мэдэгдэнэ.

Төмөр хутга: Муу хадгалагдсан төмөр хутга. Ихэнх хэсэг эвдэрсэн, одоо байгаа урт 11.5 см, өргөн 1.3 см, зузаан 0.5 см.


Цагаан чулуут 7-р булш

N 49° 05' 24.9"

ALT 946 м

E 115° 02' 26.9"

Хэмжээ 6х5 м




Гар зураг 5. Цагаан чулуут 7-р булш.
Гадаад зохион байгуулалт

Том хавтгай боржин чулуудыг ашиглан хойд зүг чиглүүлэн үйлдсэн зуувандуу дугариг хэлбэртэй овгор булш. Булшны төв хэсгийн том хавтгай чулууд налан унасан байдалтай. Чулуун дараасын голд хойд зүг чиглэсэн 3.2х1 м хэмжээтэй чулуугүй хэсэг байна. 7х6 м хэмжээтэй тэг татан цэвэрлэгээг 35 см гүн хийхэд чулуун дараасны өмнө хэсгээс бог малын шаант яс илрэв. 60 см гүнээс талбайн төв хэсэгт хойд зүг чиглэсэн 200х75 см хэмжээтэй бор өнгийн хөрстэй толбо илрэв. Толбыг дагуулан малтахад

эртний өнгөн хөрснөөс доош 160 см гүнд нүхний төв хэсгээс бог малын 3 ш нурууны яс, бог малын ясны хугархай хэсэг илрэв. Эд өлгийн зүйл үгүй, эрт үед тоногдсон оршуулга байв. (Фото зураг 21-22. Гар зураг 5).

Цагаан чулуут 10-р булш

N 49° 05' 24.4" ALT 942 м
E 115° 05' 26.7" Хэмжээ 4.3х3.8м




Гар зураг 6. Цагаан чулуут 10-р булш.
Гадаад зохион байгуулалт

Цагаан чулуутын оршуулгын газрын зүүн доод хэсэгт орших дугариг булш. Чулуун дараасын төв хэсэгт хойд зүг чиглэсэн 190х60 см чулуугүй хонхор байна. 5х4 м хэмжээтэй тэг татан цэвэрлэгээг үйлдэхэд чулуун дараасын өмнө хэсгээс бог малын яс илрэв. Эртний өнгөн хөрснөөс доош 30 см гүнд хойд зүг чиглэсэн төв хэсэгтээ чулуун өрлөг бүхий толбо илрэв. Толбоны хэмжээ 210х80 см. Толбыг үргэлжлүүлэн малтахад 130 см гүнээс оршуулга илрэв. Нас барагчийн тэргүүнийг чанх

хойд зүг хандуулан тэнэгэр байдалтай оршуулжээ. Гавлын яс анхны байрлалаа алдаж доош харсан, хүзүүний нугалам яснууд зүүн мөрний орчимд бөөгнөрсөн байна. Гавлын ясны дагзны хэсэгт хүрэл эдлэлтэй ойр байсны ул мөр тод үлджээ. Зүүн гарын шуу, сарвуу яснууд хөдөлж, баруун дунд чөмөгний ясны дээгүүр тэгнэсэн байдалтай олдов. Хүний зүүн эгэм, далны ясны орчимд хүний хуйх, үсний хэсэг хадгалагдан үлдсэн байсныг битүүмжлэн авав. Зүүн хөлийн доор голдоо нүх бүхий тугалган сум хүндрүүлэгч булцуу дагалдуулжээ. Хүний ууцны доор бага хэмжээний газар ухаж, түүндээ бог малын нурууны гурвван ширхэг нугалам байршуулжээ. Нас барагчийг модон хашлаганд оршуулсныг толгой хэсгээр хадгалагдан үлдсэн банзны үлдэгдлээс мэдэж болохоор байна. Уг булшинд насанд хүрсэн эрэгтэй хүнийг оршуулсан бөгөөд тонуулчид толгой хэсгийг тоножээ (Фото 23-24, гар зураг 6).

Цагаан чулуут 12-р булш

N 49° 05' 24.9" ALT 946 м
E 115° 02' 26.2" Хэмжээ 3.62х3.7 м



Гар зураг 7. Цагаан чулуут 12-р булш.
Гадаад зохион байгуулалт

Газрын хөрсөн дээр цөөн тооны чулууд цухуйж байсныг цэвэрлэн үзэхэд уг булшны гадаад зохион байгуулалт тодорхой харагдав. Дунд зэргийн чулуудаар хийсэн дугуй булш агаад дараасын төв хэсэгт хойд зүг чиглэсэн чулуугүй хонхор талбайтай ажээ. Цэвэрлэгээний явцад уг чулуугүй талбай орчмоос бог малын чөмөгний яс илэрсэн

болно. 5x5 м-ийн хэмжээтэй тэг татан малтахад 50 см гүнд талбайн төв хэсэгт толбо илрэв. Хойд зүг чиглэсэн, толгой хэсэгтээ 2 том чулуу бүхий 195x63 см хэмжээтэй толбо байна. Мөн энэ түвшинд бод малын далны яс илрэв. 123 см гүнээс модон авсанд оршуулсан хүүхдийн оршуулга илрэв. Нас барагчийн 2 хөлийн яснаас бусад нь анатомийн байрлалаа бүрэн алдсан байдалтай байлаа. Нүхний толгой хэсгээр тараан хаясан хүний хавирга, нурууны нугалам яснууд дундаас мөнгөн гархин ээмэг, төмөр хутганы үлдэгдэл олдлоо. Эрүүний яс авсны зүүн хойд булангаас илрэв. Уг банзан авс 142 см урт, толгой хэсгээрээ 62 см, хөл хэсгээрээ 51 см-ийн өргөнтэй, 30 см өндөр байна. Тонуулчдад хөндөгдөлгүй үлдсэн хүний хөлийн ясыг үндэс болговол нас барагчийг хойд зүг хандуулан тэнэгэр байдалтай тавьсан ба 16-17 насны эмэгтэй хүүхдийн оршуулга ажээ (Фото зураг 25-26. Гар зураг 7).


Олдворын тодорхойлолт:

Ээмэг: Жижиг мөнгөн гархи. Диаметр 1.1 см.

Цагаан чулуут 18-р булш

N 49° 05' 25.1' ALT 948 м
E 115° 02' 2.8" Хэмжээ 3.6x3.2м

Оршуулгын газрын хамгийн доод хэсэгт орших том хавтгай чулуудыг ашиглан хийсэн дугариг хэлбэрийн булш. Чулуун дараасын төв хэсэгт хойд зүг чиглэсэн 90x120 см чулуугүй хотгор талбайтай. Толгой хэсгийн чулууд доош сууж булагдсан байдалтай. 5x5 м хэмжээтэй тэг татан талбайлан цэвэрлэгээг үйлдэхэд дараасын өмнөд хэсгээс бод малын шилбэний яс илрэв. Эртний өнгөн хөрснөөс доош 40 см гүнээс хойд зүг чиглэсэн толбо бүрэн тодров. 140 см гүнд оршуулга илрэв. Хүний сүүж, тахилзуур, шилбэ болон хурууны үе, нугалам, хавирга зэрэг яснууд эмх замбараагүй байдалтай байлаа. Эмх замбараагүй болсон



Гар зураг 8. Цагаан чулуут 18-р булш.
Гадаад зохион байгуулалт

байлаа. Оршуулгын нүхний толгой орчимд 40 см ханалан ухаж хөмөг үйлдсэн бөгөөд түүндээ бог малын дал, шагайт чөмөг дагалдуулан тавьжээ (Фото зураг 27-28, Гар зураг 8).

Цагаан чулуут 164-р булш

N 49° 05' 26.0" ALT 949 м
E 115° 02' 26.5" Хэмжээ 2.5х3.9м



Гар зураг 9. Цагаан чулуут 164-р булш.
Гадаад зохион байгуулалт

хүний яснууд дундаас 3ш сувс, 1ш цэнхэр өнгийн чулуун зүүлт илрэв. Нүхний зүүн доод хананд шахан тавьсан үйлийн төмөр хайч, төмөр хутга, хүрэл толь зэрэг зүйлс анхны байрлалаа хадгалан үлдсэн байна. Үйлийн хайч болон төмөр хутгыг хошууг нь хойд зүг хандуулан зэрэгцүүлэн тавиад түүн дээрээ ногоон өнгийн хүрэл толийг доош харуулан 6 айрлуулжээ.


Булшны нүхний энд тэндээс үйсэн эдлэлийн хэсгүүд олноор олдож

Энэ нь Цагаан чулуутын хамгийн өндөр, боржин хадтай толгойн урд доор байрлах жижиг булш. Анх газрын хөрсөн дээр 3ш жижиг чулуудаар танигдаж байсныг талбайлан цэвэрлэхэд зүүн хойд зүг чиглэсэн дугариг хэлбэртэй чулуун дараас илэрч 60 см гүнд зүүн хойд зүг (15°) чиглэсэн жижиг чулууд бүхий толбо илрэв. 200х90 см хэмжээтэй. 70 см гүнд нүхний толгой орчмоос хөндлөн тавьсан үйсэн

хоромсого, зүүн хойд өнцгөөс үйсэн саадагны хэсэг илрэв. Доош 10 см малтахад нүхний төв хэсгээс дэлгээ байдалтай үйсэн саадагны үлдэгдэл, олон тооны жижиг хэсгүүдийн хамтаар олдлоо. Мөн эдгээр үйсэн дундаас 2ш төмөр зэв илрэв. 143 см гүнээс маш их тоногдсон оршуулга илрэв. Анхны байрлалаа алдалгүй үлдсэн зүйлс огт үгүй. Энэхүү оршуулгаас хүний толгойноос бусад яс болон 1 ш дархны төмөр зээтүү, 14 ш төмөр зэв, 1 ш ясан дуут булцуу, 8 ш төмөр хадаас, 2 ш төмөр чимэглэл, 1 ш төмөр арал, 5 ш бүсний хүрэл чимэглэл, богийн шагайт чөмөг, нумын ясан бариул зэрэг зүйлс тодорхой зохион байгуулалтгүй олдлоо. Нүхний толгой хэсэгт 33х27 см хэмжээтэй нүх ухан хөмөг үйлдсэн ба түүндээ бог малын шагайт чөмгийг байрлуулсан байна. Их биеийн ясны байдлаас үзвэл 25-30 орчим насны эрэгтэй хүний оршуулга байжээ (Фото зураг 30-32, гар зураг 9).

Цагаан чулуут 165-р булш

N 49° 05' 26.4" ALT 952 м
E 115° 02' 27.0" Хэмжээ 3.7х3.3м



Гар зураг 10. Цагаан чулуут 165-р булш.
Гадаад зохион байгуулалт


Цагаан чулуутын оршуулгын газрын хамгийн дээд хэсэгт орших голдоо чулуугүй хонхор бүхий жижиг дугуй булш. Цэвэрлэгээний явцад чулуун дараасын хойд хэсгээс жижиг хүрэл толь болон урт төмөр хутга илрэв. Эртний өнгөн хөрснөөс доош 55 см гүнд чулуу дугуйруулан зоосон, битүү чигжээс бүхий өрлөг илрэв. 1.1 м гүнээс зүүн урагш (100°) чиглэсэн зууван чулуун хашлага илэрсэн болно. Хашлагын өндрийг жигдлэхийн тулд баруун

буюу хөл талын хашлагыг 3-4 үе, зүүн урд толгой хэсгийн хашлагыг дан үе хавтгай чулуудаар дугуйруулан хийсэн. Хашлагын урт 185см, хөл хэсгийн өргөн 75см, толгой хэсгийн өргөн 100см, өндөр 55см. Уг чулуун хашлагын төв хэсэгт хүний гавал, эрүү, хавирга, нуруу, эгэм, хурууны яснууд эмх замбараагүй байдалтайгаар олдсон ба хүний хөлийн яснууд анхны байрлалаа хадгалан үлдсэн байна. Хөлийн ясны байрлалаас харвал нас барагчийн тэргүүнийг зүүн урд зүгт

хандуулан баруун хажуугаар нь хэвтүүлж, хөлийг өвдгөөр атийлган оршуулсан бололтой. Хүний сүүжний яс орчимд муу хадгалагдсан төмөр эдлэл дагалдуулсан нь үлджээ. Уг оршуулгаас илэрсэн гавлын ясны зулай орчимд мохоо зүйлээр цохисны дүнд бий болсон том хэмжээний нүх байгаа нь сонирхол татаж байна (Фото зураг 33-34. Гар зураг 10).

Цагаан чулуут 166-р булш

N 49° 05' 25.6" ALT 952 м
E 115° 02' 28.6" Хэмжээ 3.1х3.55м



Гар зураг 11. Цагаан чулуут 166-р булш

Цагаан чулуутын зүүн урд дэнжид бусдаас зайдуу орших жижиг, дугариг булш. Эртний өнгөн хөрснөөс доош 43 см-т толбо илрэв. Зүүн хойш (30°) чиглэсэн 144х60 см хэмжээтэй. Толбоны дагуу малтлагыг үргэлжлүүлэхэд 85 см гүнээс эрт үед тоногдсон хүүхдийн оршуулга илрэв. Хөлийн яснаас бусад яс анатомийн байрлалаа алдсан. Гавлын яс үгүй. 3ш шүд илрэв. Толгой хэсэгт босгон тавьсан богийн шагай, маш муу хадгалагдан үлдсэн жижиг төмөр хутга зэрэг зүйлс илрэв. Хөлийн ясны байрлалаас харвал хүүхдийн толгойг зүүн хойд зүгт хандуулан тэнэгэр байдалтай оршуулсан бололтой (Фото зураг 35-36, гар зураг 11).

Хүснэгт 2.

ЦАГААН ЧУЛУУТЫН ОРШУУЛГЫН ГАЗАРТ ХИЙГДСЭН МАЛТЛАГА СУДАЛГААГААР ИЛЭРСЭН ЗАРИМ ОЛДВОРЫН КАТАЛОГИ

Д/д	Олдворын нэр	Булш, Лабораторийн дугаар	Товч тодорхойлолт	Фото зураг
1	Төмөр дөрөө	Б-6 ЦЧ-6-1	<i>Төмрөөр цутган хийсэн дөрөө. Хавтгай тавагтай, нуман хэлбэртэй бөгөөд тэг голоороо сэтэрсэн байдалтай. Өндөр 16.6 см, өргөн хамгийн их хэсэгтээ 13.9 см, дөрвөлжин сэнжтэй, сэнжний өндөр 3.2 см, өргөн 4.9 см, Тавагны өргөн 5.6 см. Хацрын өргөн 1.1 см. Хадгалалт сайн.</i>	
2	Төмөр дөрөө	Б- 6 ЦЧ-6-2	<i>Жижиг дөрөө: Өндөр 12.6 см, өргөн 12.6, сэнжний өргөн 2.4 см, сэнжний өндөр 2 см. Таваг 2 см. Тавагны нэг тал сэтэрхий түүний хэмжээ 4.1х1.1см.</i>	

3	Сум хүндрүү- лэгч булцуу:	Б- 10 ЦЧ-10-1	Тугалгаар хийсэн. Сумны зэвний ард хүндрүүлэгч байдлаар хэрэглэж байсан бололтой. Өндөр нь 2 см, суурийн диаметр 2.4 см.	
4	Хүрэл толь:	Б- 18 ЦЧ-18-1	Хээ чимэглэл багатай хүрэл толь. Ирмэг хэсгийг нарийн зураасаар хүрээлсэн. Тойргын төв хэсэгт бариултай. Сэнжийг тойруулан 2 нарийн зураасаар тойрог хээг дугуйлсан. Сэнжний хэсэгт сурны үлдэгдэл бүхий. Диаметр 12.3 см. Зузаан 0.3 см.	
5	Үйлийн төмөр хайч:	Б- 18 ЦЧ-18-2	Маш муу хадгалагдсан. Бариул нь хагас эргэсэн байдалтай. Нийт урт 20 см, бариулын урт 10 см.	
6	Чулуун зүүлт	Б- 18 ЦЧ-18-3	Цагаан болон ногоон өнгийн чулуугаар хийсэн жижигжисг зүүлт. Нийт 5 ш.	
7	Нумын ясан барил:	Б- 164 ЦЧ-164-1	Малын чөмөгний ясыг голоор нь цуулан сайтар өнгөлөн хийсэн нумын ясан барил. Урт 13.5 см, өргөн 1.7 см.	

8	Төмөр хадаас:	Б- 164 ЦЧ-164-2	<i>Нийт 8ш. Гурван талтай, нарийн үзүүр хэсгийг эргүүлэн цохиж тав гаргасан. Бүх хадаасанд модны үлдэгдэл байгаа ба модон авсыг тогтооход хэрэглэж байсан бололтой.</i>	
9	Төмөр арал:	Б- 164 ЦЧ-164-3	<i>Эмээлийн олом бололтой. Төмөр хэл бүхий, дөрвөлжин хэлбэртэй, 3.5х3.2 см.</i>	
10	Төмөр эдлэл	Б- 164 ЦЧ-164-4	<i>Нимгэн, хавтгай дөрвөлжин хэлбэртэй. Нэг талын үзүүр нь эргэсэн байдалтай буюу булан үүсгэсэн. Зах хэсэгтээ хадан тогтоох үүрэг бүхий 2 хадаастай. Хадааснуудыг эргүүлэн цохисон байдалтай аж. Авсны буланг тогтоох зориулалтаар хэрэглэж байсан бэхэлгээ төмөр бололтой. Өргөн 3.2 см.</i>	
11	Төмөр эдлэл :	Б- 164 ЦЧ-164-5	<i>Ойролцоогоор 7.3 см хэмжээтэй. Хүнхэр хэлбэртэй төмөр эдлэл ба даавуун эдлэлээр битүү бүрхэж байсан байна.</i>	

12	Хүрэл чимэглэл	Б- 164 ЦЧ-164-6	<i>Нийт 4ш. Хагас цагариг хэлбэртэй. Нэг тал нь хавтгай, нөгөө тал нь 5 товгорттой. Хавтгай талдаа 2 ш хадаастай агаад бүгдийг эргүүлэн цохьжээ. Суранд бэхэлсэн байдалтай олдсон ба хазаарын чимэглэл байсан бололтой.</i> <i>Хүрэл эдлэл 1ш. Тэгш дөрвөлжин хэлбэртэй. Гол дундаа дугуй нүхтэй. Ирмэгүүдийг ухан гаргасан нь дэлбээ мэт хэлбэрийг үүсгэсэн. Суранд бэхлэгдсэн байдалтай байгаа нь дээрх хүрэл чимэглэлүүдтэй ижил зориулалтаар ашиглаж байсныг харуулна. Хэмжээ 1.7х1.7 см.</i>	
13	Төмөр алх	Б- 164 ЦЧ-164-7	<i>Дархны төмөр алх: Толгой хэсгийн нэг тал нь дөрвөлжин, нөгөө тал нь шөвгөр буюу зээтүүний үүрэг гүйцэтгэх зориулалттай ажээ. Урт нарийн бариултай. Нийт урт 31 см, толгойн өргөн 1.4 см, урт 8.3 см, шилбэний урт 12 см, бариулын хэсэг 17.6 см. Бариул хэсэгт модны үлдэгдлүүд байгаагаас үзвэл модон иштэй байсан бололтой. Алхны цохилтын талбай 1х1 см. Мааш нарийн зүйл хийх зориулалт бүхий дархны алх бололтой.</i>	

14	Зэв:	Б- 164 ЦЧ-164-8	1-р зэв: Хэйбүр зэв: Урт 11.8 см, сурвалжний урт 5.6 см 2-р зэв: Хэйбүр зэв: Урт 11.1 см, сурвалжны урт 5.7 см. 3-р зэв: Хэйбүр зэв: Урт 11 см, сурвалжны урт 6.9 см. 4-р зэв: Хануур сум. Урт 13.9 см, сурвалжны урт 7.6 см. 5-р зэв: Хануур сум. Урт 11.8 см, сурвалжны урт 5.2 см. 6-р зэв: Хануур сум: Урт 11 см. сурвалжны урт 4.5 см. 7-р зэв: Хануур сум: Урт 11 см. сурвалжны урт 4.4 см. 8-р зэв: Хануур сум: Урт 10.9 см. сурвалжны урт 4.9 см. 9-р зэв: Хануур сум: Урт 7.8 см. сурвалжны урт 1.7 см. Эвдэрсэн 10-р зэв: Хануур сум: Урт 6.9 см. Сурвалж хугарсан байдалтай. 11-р зэв: Цоморлиг бонхор: Урт 9.4 см. сурвалжны урт 3.8 см. 12-р зэв: Элээний сүүл сум: Урт 5.9 см. сурвалжны урт 3 см. 13-р зэв: Хануур сум: Урт 11 см. сурвалжны урт 4.5 см. 14-р зэв: Хадгалалт муутай, хэлбэрээ бүрэн алдсан төмөр зэв.	
15	Хүрэл толь:	Б- 165 ЦЧ-165-1	Диаметр 8.6 см, ирмэг сэтэрхий. Дундад эртний үед холбогдох хүрэл толь.	

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монголын эртний түүхийн нэгэн гол сурвалж нь булш оршуулга болно. Түүхийн олон үед холбогдох булш оршуулгыг Монгол нутагт ХХ зууны эхэн үеэс малтан шинжилж эхэлсэн бөгөөд харин дундад эртний үед холбогдох булшийг харьцангуй хожуу малтан судалсан байдаг (Пэрлээ, 1955: 19-21).

Үүнээс хойш Монгол улсын нутагт энэ үед холбогдох булшийг малтан шинжлэх ажлыг 1960-аад онд Х.Пэрлээ (1959а, 1959б, 1959в), В.В.Волков (1962: 66-67; 1963: 47-51), Ц.Доржсүрэн (1960: 3-14) нар язгуурын монголчуудын уугуул нутаг болох гурван голын сав газрын археологийн дурсгалыг судлах, Чингис хааны төрсөн газар хэмээх Дэлүүн болдогийг сурвалжлан судлах, Ховд, Өмнөговь аймгийн нутаг дах эртний Монголчуудын булшийг малтан судлах чиглэлээр хийсэн нь энэ талын шинжилгээг ахиулсан ажил болсон юм. 1980-аад оноос Д.Наваан (1986: 3-10; 2006:10-29), Д. Цэвээндорж (1986: 63-71), Г.Мэнэс (1986: 3-11; 1987: 48-51; 1992а: 7-22; 1992б: 65-78), Х.Лхагвасүрэн (1987: 87-94; 1989: 68-76; 1989б: 137-146; 2007), 1990-ээд онд З.Батсайхан (1994: 15-27), Д.Эрдэнэбаатар (1994: 90-99; 1996: 113-121), Ц.Төрбат (1997: 140-146; 2003: 66-68), Д.Эрдэнэбат (1998: 135-152; 2006) зэрэг судлаачид эртний монголчуудын оршуулгын зан үйл, эдийн соёл, он цагийн асуудлыг хөндсөн эрдэм шинжилгээний бүтээлүүдийг нийтлүүлсэн байдаг. Эдгээрийн дотор Дорнод Монголын бүс нутагт малтан судалсан дундад эртний булшнууд нь нилээд онцлогтой бөгөөд зарим булшнаас хосгүй үнэт эд өлгийн зүйлс илэрч байсан удаатай (Наваан, 2006: 10-29).

Д.Баяр 1980-аад оны дунд үеэс Дорнод Монголоор түгээмэл байх хүн чулуудыг дагнан судалж эртний Монголчуудын үлдээсэн дурсгал болохыг олон баримтаар тогтоосон нь эрдэм шинжилгээний өндөр ач холбогдолтой ажил болсон [1985:52-58; 1985а, 119-130, 1995, 1999, 2000]. Үүнээс гадна 1970-80-аад онд Д.Түмэн монголын нутгаас олдсон эртний хүний олдворын краниологийн судалгааг хийсэн нь энэ талын судалгааны эхлэл байв (1986: 85-97; 1987: 101-123).

Сүүлийн жилүүдэд МУИС-ын Археологи-Антропологийн тэнхмээс зохион байгуулсан “Дорнод Монгол” шинжилгээний анги Дорнод аймгийн Гурван Загал сумын нутаг Цагаанчулуут хэмээх газарт Монголын үед холбогдох булш малтан шинжилж байгаа бөгөөд (Наваан нар, 2008:18-20; Түмэн нар, 2009: 32-42; Түмэн нар, 2010) үүнээс өмнө 1969, 1971 онуудад энэ орчимд ШУА-ын түүхийн хүрээлэнгийн “Гурван гол” шинжилгээний анги дөрвөлжин булш малтан судлахын завсар цөөн монгол булш малтаж олон сонирхолтой эд өлгийн зүйлс илрүүлсэн байдаг (Эрдэнэбат, 2007: 219).

Энд 160 гаруй оршуулгын байгууламж тоологдсоны дийлэнх нь дөрвөлжин булш байх ба 2008 онд тэр хавьд орших булшнуудын дэвсгэр зургийг үйлдсэн байна (Наваан нар, 2008: 18-20).

“Дорнод Монгол” шинжилгээний анги 2010 онд Цагаан чулуутад дундад эртний үед холбогдох нийт 8 булш малтсан бөгөөд эдгээр булшнаас эрдэм шинжилгээний өндөр ач холбогдол бүхий олон сонирхолтой зүйлс олдлоо.

Сурвалжид бичсэнээр дундад эртний үед энэ орчимд Татаарын ханлиг голчлон нутаглаж байсан бөгөөд энэ тухай “... тэдний нутаг, сууц нь хятадын хилийн орчмоор (харин) үндсэн нутаг нь Буйр нуур билээ ...” хэмээн тэмдэглэжээ (Батсүрэн, 2003: 74).

Цагаанчулуутад малтан судалсан булш-3-аас илэрсэн хүний ясанд хийсэн C14-ийн шинжилгээгээр¹ уг дурсгал МЭ 1162-1210 оны үе буюу язгуурын монголын аймгуудыг нэгтгэн Монгол гүрэн байгуулагдаж асан үед холбогдож байгаа нь энэхүү дурсгал монголчуудын түүхэн асуудалд чухал ач холбогдолтой болохыг харуулж байна. Иймд уг дурсгалыг цаашид үргэлжлүүлэн малтан судлах зайлшгүй шаардлагатай юм.

2.2. ХАЙГУУЛ СУДАЛГАА

Хадан Хөвөө

Бид Гурванзагал сумын төвөөс баруун урагш 35 км-т Цагаан хошуу (II баг) багийн нутагт орших Хадан хөвөө хэмээх газар археологийн хайгуул судалгаа явуулж хүрэл зэвсгийн (МЭӨ IV-I мянган жил) ү

ед холбогдох 20 дөрвөлжин булш бүртгэн, хэмжилт хийн анхны баримтжуулалтыг үйлдэв. Уул булшууд нь Хадан хөвөөгийн баруун талд байх хадархаг толгодын зүүн, зүүн хойд талаар илүү бөөгнөрсөн байна. Эдгээр булш нь дөрвөн буландаа хөшөө чулуу бүхий дөрвөлжин булшны “Сонгодог” хэлбэрийг төлөөлөхүйц дурсгалууд болно. Энд ажиглагдаж буй нэгэн онцлог зүйл нь зарим булшны зүүн урд (Азимутын 50°) хөшөө чулуу босгон зоосон явдал юм.

Хүснэгт 1.

ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН ХАДАН ХӨВӨӨГИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛЫН МЭДЭЭЛЭЛ

Булшны дугаар	Солбицол	ДТД	Алдаа (м)	Хэлбэр	Хэмжээ
Хадан Хөвөө 1	N 49° 02' 00.4" E114° 40' 15.1"	779 m	4	Дөрвөлжин	4.4x2.9
Хадан Хөвөө 2	N 49° 01' 42.2" E114° 40' 21.9"	777 m	4	Дөрвөлжин	4.1x2.3
Хадан Хөвөө 3	N 49° 01' 39.2" E114° 40' 20.6"	778 m	4	Дөрвөлжин	4.2x5
Хадан Хөвөө 4	N 49° 01' 38.7" E114° 40' 20.9"	772 m	4	Дөрвөлжин	3.7x2.7
Хадан Хөвөө 5	N 49° 01' 38.5" E114° 40' 20.8"	771 m	4	Дөрвөлжин	3x2.5
Хадан Хөвөө 6	N 49° 01' 36.5" E114° 40' 18.1"	779 m	4	Дөрвөлжин	3.6x2.2

¹ C14-ийн шинжилгээг Японы “Polyno Survey3” компанийн он цаг тогтоох лабораторид судлаач Hashimoto Markio, Kanai Shinji нар хийсэн болно.

Хадан Хөвөө 7	N 49° 01' 34.0" E114° 40' 16.7"	779 m	4	Дөрвөлжин	6x3.2
Хадан Хөвөө 8	N 49° 01' 33.7" E114° 40' 11.6"	777 m	4	Дөрвөлжин	4.9x3.3
Хадан Хөвөө 9	N 49° 01' 31.5" E114° 40' 17.0"	780 m	4	Дөрвөлжин	4.8x3.5
Хадан Хөвөө 10	N 49° 01' 29.6" E114° 40' 13.8"	784 m	4	Дөрвөлжин	5.1x3.7
Хадан Хөвөө 11	N 49° 01' 30.7" E114° 40' 11.3"	782 m	4	Дөрвөлжин	3x2.4
Хадан Хөвөө 12	N 49° 01' 32.0" E114° 40' 11.5"	784 m	4	Дөрвөлжин	3.4x2.6
Хадан Хөвөө 13	N 49° 01' 35.7" E114° 40' 15.2"	774 m	4	Дөрвөлжин	4.7x3.9
Хадан Хөвөө 14	N 49° 01' 32.8" E114° 40' 07.1"	778 m	4	Дөрвөлжин	3x2.7
Хадан Хөвөө 15	N 49° 01' 34.0" E114° 39' 45.8"	792 m	4	Дөрвөлжин	4.1x3.2
Хадан Хөвөө 16	N 49° 01' 47.5" E114° 39' 48.8"	787 m	4	Дөрвөлжин	4.4x3.6
Хадан Хөвөө 17	N 49° 01' 51.3" E114° 39' 48.0"	784 m	4	Дөрвөлжин	5x3.5
Хадан Хөвөө 18	N 49° 01' 52.3" E114° 39' 44.9"	790 m	4	Дөрвөлжин	4.1x3.1
Хадан Хөвөө 19	N 49° 01' 33.7" E114° 40' 00.0"	777 m	4	Дөрвөлжин	3.7x2.3
Хадан Хөвөө 20	N 49° 01' 53.8" E114° 40' 08.0"	779 m	4	Дөрвөлжин	5.4x3.3

ДУГНЭЛТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын орчимд МУИС-ийн Археологийн хээрийн шинжилгээний анги ажиллахдаа нийт 181 дурсгал бүртгэж, 6 дурсгалыг зохих журмын дагуу малтан судлав.

Энэ орчмын дурсгалууд нь урьд өмнө судлаачдын хараанд өртөж, эрдэм шинжилгээний эргэлтэнд ороогүй чухал дурсгалууд байлаа. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт буй Улаан зуух орчмын хүрэл зэвсгийн үед холбогдох булшнууд нь Өвөр байгаль, Өвөр Монгол, Шинжаан, Манжуурын бүс нутагт тархсан энэ үед холбогдох дөрвөлжин булшнуудаас гадаад зохион байгуулалт, оршуулгын зан үйл, дагалдуулж тавьсан эд өлгийн зүйлсээрээ нилээд ялгаатай байна. Энд хийсэн малтлага судалгаагаар түрүүлгэ нь харуулан оршуулах зан үйл, хүрэл зэвсгийн түрүү үед холбогдох ваар савны хагархай, чулуун зүүлт, дөрвөлжин булшны үндсэн гадаад зохион байгуулалтаас өөр хэв шинж зэрэг өмнө үед судлагдсан хүрлийн үеийн археологийн дурсгалуудаас нэлээн ялгаатай эд өлөг зан үйлүүдийг илрүүлээ.

Дорнод аймгийн Гурван загал сумын нутаг Цагаанчулуутын орчимд шинэ чулуун зэвсэг, хүрэл, монголын үеийн археологийн цогцолбор дурсгалууд байгаад үндэслэн уг нутагт түүхэн олон үед монголчуудын өвөг дээдэс үе улиран нутаглаж байжээ гэсэн дүгнэлт хийж болох юм. Цагаанчулуут дахь Монголын үеийн булшны дурсгалууд нь булшны гадаад дотоод зохион байгуулалт, дагалдуулсан эд өлгийн зүйлс, олдворуудаараа монголын бусад бүс нутаг болон Монголын зүүн хойт нутаг, Өвөр Байгалын түүхэн мөн үеийн дурсгалуудтай адил байгаа юм. Уг дурсгал нь язгуурын монгол аймгуудыг нэгтгэн Монгол гүрэн байгуулагдаж байсан үед хамаарахыг C^{14} -ийн шинжилгээгээр тогтоолоо.

2010 оны хээрийн судалгаагаар Дорнод аймгийн Гурванзагал сумын төвөөс баруун урагш 35 км-т Цагаан хошуу багийн нутагт орших Хадан хөвөө хэмээх газарт археологийн хайгуул судалгаа явуулж хүрэл зэвсгийн (МЭӨ IV-I мянган жил) үед холбогдох 20 дөрвөлжин булш бүртгэн, хэмжилт хийн анхны баримтжуулалтыг үйлдэв. Эдгээр булш нь 4 буландаа хөшөө чулуу бүхий дөрвөлжин булшны “Сонгодог” хэлбэрийг төлөөлөхүйц дурсгалууд бөгөөд зарим булшны зүүн урд (азимутын 50°) хөшөө чулуу босгон зоосон байлаа.

НОМ ЗҮЙ

- Амартүвшин Ч., 2003. Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд. Түүхийн ухааны дэд докторын зэрэг горилсон зохиол. УБ
- Амартүвшин Ч., Ерөөл-Эрдэнэ Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., 2007. Эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлийн өвөрмөц нэгэн хэлбэр. SA. Tom (IV), XXIV. Fasc. 11, УБ
- Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Амгалантөгс Ц., Жаргалан Б., 2008. Ухаа худагт хийсэн археологийн малтлага судалгааны үр дүн. SA. Tom (VI) XXVI. Fasc. 11, УБ
- Амартүвшин Ч., Жаргалан Б., 2008. Бага газрын чулуунд хийсэн хүрэл зэвсгийн түрүү үеийн булшны судалгаа. SA. Tom (VI) XXVI. Fasc. 5. УБ
- Амартүвшин Ч., Амгалантөгс Ц., Галдан Г., Жаргалан Б., 2010. Барууннаранд хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүн. Нүүдэлчдийн өв судлал. Tom X. Fasc. 3. УБ
- Батсайхан З., 1994. Эрт, дундад үеийн монгол угсаатны түүхэнд холбогдох нэгэн хэрэглэгдэхүүний тухай. ШУА-ийн мэдээ. УБ. 1994. №1
- Батсайхан З., 2002. Хүннү. УБ
- Батсүрэн Б., 2003. Монголын эртний улсуудын нутаг дэвсгэр (Түүхэн газар зүйн шинжилгээ). УБ.
- Баяр Д., 1985. К проблеме датировки каменных изваяний Дариганги. Информационный бюллетень МАИКЦА, Вып. 6, М.
- Баяр Д., 1985а. Дорнод Монголоос олдсон эмэгтэй хүний дүрст хүн чулуун хөшөө. БНМАУ-ын ШУА-ийн мэдээ. УБ., №2
- Баяр Д., 1995. Монголчуудын чулуун хөрөг (XIII-XIV зуун). Анхдугаар хэвлэл. УБ.
- Баяр Д., 2000. Алтан ургийн язгууртны нэгэн булшийг судалсан нь. УБ
- Волков. В.В., 1962. Эртний монгол булш. БНМАУ-ын ШУА-ийн мэдээ. № 4, УБ

- Волков В.В.*, 1963. 1959 онд Дундговь аймгийн нутагт эртний судлалын хайгуул хийсэн тухай. SA. Tomus II, Fasc. 2, УБ
- Волков В.В.*, 1967. Бронзовый и ранний железный век Северной Монголии. УБ.
- Гришин Ю.С.*, 1980. О фигурных плиточных могилах Забайкалья и Монголии. КСИА. Вып. 162
- Диков Н.Н.*, 1958. Бронзовый век Забайкалья. Улан-Удэ
- Доржсүрэн Ц.*, 1960. Чингис хааны төрсөн Дэлүүн Болдог хаана байна. SA. Tomus I, Fasc.6, УБ
- Киселев С.В.*, 1947. Монголия в древности. Известия АН СССР. Том. IV. Вып. 4. М.
- Лхагвасүрэн Х.*, 1987. Монгол булшны судалгааны асуудалд. БНМАУ-ын ШУА-ийн мэдээ. №1, УБ
- Лхагвасүрэн Х.*, 1989. XI-XIII зууны монголчуудын булшууд. БНМАУ-ын ШУА-ийн мэдээ. УБ
- Лхагвасүрэн Х.* 1989б. *Буурал уулын монгол булшууд* // SH. Tomus XXIII, Fasc.15, УБ
- Лхагвасүрэн Х.*, 2007. Монголын археологи (Чингис хааны үе). Тэргүүн дэвтэр. УБ
- Мэнэс Г.*, 1986. О семантике “Ульген”. Исследования по исторической этнографии монгольских народов. Улан-Удэ
- Мэнэс Г.*, 1987. К вопросу о способе определения стран света в традиционной системе ориентации монголов. SA. Tomus XXI, Fasc. 7, УБ
- Мэнэс Г.*, 1992а. Символика солнца в системе погребального обряда монгольских племен. Археологическое памятники эпохи средневековья в Бурятии и Монголии. Новосибирск
- Мэнэс Г.*, 1992б. О возможности территориально-хронологической локализации начального этапа этногенеза монгольской этнокультурной общности. SH. Tomus XXV, Fasc. 6, УБ
- Наваан Д.*, 1986. Дундад зууны үеийн монголчуудын оршуулах зан үйлийг судлах асуудалд. SA. Tomus XI, Fasc. 1, УБ
- Наваан Д., Мөнхдэлгэр Ж.*, 2006. Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн 5-р булш ба Монголын язгууртны булш судлах асуудалд. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Official Journal of the National University of Mongolia, Vol. 2, No.1 (254), УБ
- Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., Түмэн Д.*, 2008. “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2008 онд хийж гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгаа. Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 4, № 1(312).
- Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., Түмэн Д.*, 2009. “Дорнод монгол” төслийн хүрээнд 2009 онд хийж гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгааны ажлын тайлан. МУИС, Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ
- Новгородова Э.А.*, 1989. Древняя Монголия. М.
- Окладников А.П., Кириллов И.И.*, 1980. Юго-Восточное Забайкалье в эпоху камня и ранней бронзы. Новосибирск.
- Пэрлээ Х.*, 1955. Сүн улсын үеийн булш. Шинжлэх ухаан, №3, УБ
- Пэрлээ Х.*, 1959а. Онон Хэрлэнгийн монголчууд. Шинжлэх ухаан. №5-6, УБ
- Пэрлээ Х.*, 1959б. Нэгэн шарилын тухай. SM. Tomus I, Fasc. 1, УБ
- Пэрлээ Х.*, 1959в. Онон Хэрлэнгийн монголчууд (VII-XII зуун). Шинжлэх ухаан, техник. №5-6, УБ

- Сосновский Г.П.*, 1928. Фигурные могилы. Материалы. Архив Г.П.Сосновского. Архив. ИИМК. АН. Ф-42. №251. (дам ишлэв)
- Төрбат Ц.*, 2003. Эртний монголчуудын оршуулгын дурсгалын зүг чиг. SA. Tomus I (XXI), Fasc. 6, УБ
- Төрбат Ц., Батсайхан З.*, 1997. Эртний монголчуудын археологийн дурсгалыг судлах асуудалд (МЭ VIII-XV зуун). МУИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн эрдэм шинжилгээний бичиг 9 (126)/17, УБ
- Түмэн Д.*, 1986. Палеоантропологический материал монгольского времени из Хар-Хорина. SA, Tomus XI, Fasc.8, УБ
- Түмэн Д.*, 1987. Антропологический тип монголов и проблемы их происхождения. Актуальные проблемы современного монголоведения. УБ
- Түмэн Д., Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д.*, 2008. Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойд хийсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ
- Түмэн Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., Ванчигдаш Ч.*, 2010. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Сүмбэр, Билүүт, Тооройн шанд, Номгон сумын Ганзагад, Заг сүүжийн талбайд явуулсан археологийн хайгуул, малтлага судалгааны тайлан. УБ.
- Цэвээндорж Д.*, 1986. Эртний оршуулга. SA. Tomus XI, Fasc.6, УБ
- Цэвээндорж Д., Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., Батболд Н., Ерөөл-Эрдэнэ Ч., Базаргүр Д., Болорбат Ц., Гантулга Ж.*, 2005а. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь “Айвенхоу Майнз Монголия Инк” компаний ашиглалтын талбайд хийсэн малтлага судалгааны ажлын тайлан. ШУА, АХ ГБСХ. УБ
- Цэвээндорж Д., Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., Цэрэндагва Я., Болдохуяг Д., Мөнхтулга Р., Хүрэлсүх С., Номгуунсүрэн Г., Чинзориг Б., Эрдэнэ-Очир Н.*, 2005б. Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутаг дахь Тайширын усан цахилгаан станцын ашиглалтын талбайд буй археологийн дурсгалыг авран хамгаалах хээрийн шинжилгээний ангийн эрдэм шинжилгээний ажлын тайлан. ШУА, АХ ГБСХ.
- Цыбиктаров А.Д.*, 1998. Культура плиточных могил Монголии и Забайкалья. Улан-Үдэ.
- Эрдэнэбаатар Д.*, 1994. Монголчуудын шагай, шагай чөмөг эрхэмлэх ёсны тухай (VII-XIV зуун). SH. Tomus XXVII-XXVIII, Fasc. 10, УБ
- Эрдэнэбаатар Д.*, 1996. Монгол Алтайн хадны оршуулга. SA. Tomus XVI, Fasc.9, УБ
- Эрдэнэбаатар Д., Ковалев.А.А.*, 2009. Тэвшийн соёл. УБИС. НУФ. Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг. №4 (3). УБ
- Эрдэнэбат У.*, 1998. Эгийн голын савд малтсан монгол булшны тухайд. SA. Tomus XVIII, Fasc. 13, УБ
- Эрдэнэбат У.*, 2006. Монгол эхнэрийн богтаг малгай. УБ
- Эрдэнэбат У.*, 2007. Монгол улсын нутаг дэвсгэрт дундад зууны Монголчуудын булш, оршуулгын дурсгалыг судалсан тойм. Боть 32. Монголын археологийн шинжлэх ухаан. Монгол улсын шинжлэх ухаан. 108 боть.УБ.

SUMMARY

Д.Түмэн, М.Эрдэнэ, Д.Хатанбаатар, Г.Анхсанаа, Ч.Ванчигдаш

ARCHAEOLOGICAL FIELDWORK IN THE EASTERN MONGOLIA IN 2010

During the fieldwork in 2010, archaeological team of the Department of Archaeology and Anthropology, NUM, conducted an extensive survey in Khentii, Sukhbaatar and Dornod aimags and discovered several unknown before to scientists archaeological sites belonging to Bronze, Xiongnu and Mongolian periods. There are found 181 graves in total in five sites in the area investigated:

Ulaanzuukh site – 64 rectangular graves and one figures grave

Uvdug site – One stone wall and 10 rectangular graves

Adgiin gol – 89 rectangular graves

Dongoin shiree – One sacrificial site belonging to Turkic period

Khalkh khoshuu – Two xiongnu graves, 9 slab graves, 5 graves from Mongolian period

In total 6 graves are excavated during the expedition in Ulaanzuukh and Tsagaanchuluut sites.

Cultural and chronological aspects of the Ulaanzuukh site, and its unusual burial ritual - to bury deceased face down, is discussed in the paper, with relation to “slab” and “figured” graves - as a link between these two cultures.

The excavation of graves at Tsagaanchuluut site, Gurvanzagal soum, Dornod aimag, gave various artefacts demonstrating traditional culture, religion and social status of ancient nomads from 12-13c, when the Mongolian Empire was founding on the unification of the innate Mongolian tribes.

**СҮХБААТАР АЙМАГ, ТҮВШИНШИРЭЭ СУМЫН УЛААН ЗУУХЫН
ДУРСГАЛЫН МАЛТЛАГА СУДАЛГАА**



Фото зураг 1. Улаан зуухын оршуулгын газар малтан судалсан булшнуудын гадаад зохион байгуулалт



**Фото зураг 2. Улаан зуух, Булш 1.
Гадаад зохион байгуулалт**



**Фото зураг 3. Улаан зуух, Булш 1.
Оршуулга**



Фото зураг 4. Улаан зуух, Булш 2.
Гадаад зохион байгуулалт



Фото зураг 5. Улаан зуух, Булш 2.
Оршуулга



Фото зураг 6. Улаан зуух, Булш 3.
Гадаад зохион байгуулалт (Баруун
урдаас)



Фото зураг 7. Улаан зуух, Булш 3.
Гадаад зохион байгуулалт (Баруун
хойноос)



Фото зураг 8. Улаан зуух, Булш 3.Оршуулга



Фото зураг 9. Улаан зуух, Булш 3а, 4. Гадаад зохион байгуулалт



Фото зураг 10. Улаан зуух, Булш 3а. Оршуулга



Фото зураг 11. Улаан зуух, Булш 4. Оршуулга, чулуун хайрцаг



Фото зураг 12. Улаан зуух, Булш 5. Гадаад зохион байгуулалт



Фото зураг 13. Улаан зуух, Булш 5. Цэвэрлэгээний дараа




Фото зураг 14. Улаан зуух, Булш 5. Ханын өрлөг



Фото зураг 15. Улаан зуух, Булш 5. Дотор өрлөг



Фото зураг 16. Улаан зуух,
Булш 5. Оршуулга



Фото зураг 17. Улаан зуух, Булш 6.
Гадаад зохион байгуулалт



Фото зураг 18. Улаан зуух, Булш 6.
Цэвэрлэгээний дараа



Фото зураг 19. Улаан зуух,
Булш 6. Оршуулга

**ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМ, ЦАГААН ЧУЛУУТЫН
ДУРСГАЛЫН МАЛТЛАГА СУДАЛГАА**



Фото зураг 20: Цагаан чулуут, Булш 6. Оршуулга



Фото зураг 21: Цагаан чулуут, Булш 7. Чулуун дараас

Фото зураг 22: Цагаан чулуут, Булш 7. Оршуулга



Фото зураг 23: Цагаан чулуут, Булш 10.
Гадаад зохион байгуулалт



Фото зураг 24: Цагаан чулуут,
Булш 10. Оршуулга



Фото зураг 25: Цагаан чулуут, Булш 12.
Гадаад зохион байгуулалт



Фото зураг 26: Цагаан чулуут,
Булш 12. Оршуулга



Фото зураг 27: Цагаан чулуут, Булш 18.
Гадаад зохион байгуулалт



Фото зураг 28: Цагаан чулуут,
Булш 18. Оршуулга



Фото зураг 29: Цагаан чулуут, Булш 164.
Гадаад зохион байгуулалт



Фото зураг 30: Цагаан чулуут, Булш 164.
Нүхний чигжээс чулуу



Фото зураг 31. Цагаан чулуут, Булш 164. Оршуулга



Фото зураг 32: Цагаан чулуут, Булш 165.
Гадаад зохион байгуулалт



Фото зураг 33: Цагаан чулуут,
Булш 165. Оршуулга





Фото зураг 34: Цагаан чулуут, Булш 166.
Гадаад зохион байгуулалт




Фото зураг 35: Цагаан чулуут,
Булш 166. Оршуулга

“ДОРНОД МОНГОЛ” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ЯВЦАД
ИЛРҮҮЛСЭН АРХЕОЛОГИЙН ЗАРИМ ДУРСГАЛУУДЫН БАЙР ЗҮЙН ЗУРАГ






Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Энгэрийн бууцан дахь хүрэл, хүннү, монголын үеийн археологийн дурсгалуудын байриил




*Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Халх хошуун дахь хүннү,
монголын үеийн археологийн дурсгалуудын байршил*




Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Булгийн эхэн дэх хурлийн үеийн археологийн дурсгалуудын байршил



Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Адгийн гол дахь хүрлийн үеийн археологийн дурсгалуудын байршил



Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Улаан зуухан дахь хүрлийн үеийн археологийн дурсгалуудын байршил



Дорнод аймгийн Гурванзагал сумын нутаг Цагаан чулуут дахь хүрэл, монголын үеийн археологийн дурсгалуудын байршил